МАНАЙ СОНИНЫ I УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,123.386... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.12.28. Лхагва. №243, 244 (4613, 4614) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




ОНЦЛОХ ХУУДАС

2016 ОНЫ ОНЦЛОХ 10 ҮЙЛ ЯВДАЛ

VIII-IX нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

ДЭЛХИЙ ДАХИНД ӨРНӨСӨН ОНЦЛОХ 10 ҮЙЛ ЯВДАЛ

X-XI нүүрт

Дугаарын 60 мөр

## Сайхан баярлаарай

Ч.ЧУЛУУН

“Тогос шиг гоёж гараад, тогонд цохиулсан юм шиг орж ирэхийг шинэ жил тэмдэглэх гэнэ ээ” гэх инээдэмтэй атлаа үнэн үг цахим ертөнцөөр аялж, түүнд нь маш олон хүн сэтгэгдэл бичжээ. Зарим нь эл өдрийг ганц олдох аз жаргал мэт санан хөөрч сагсуурч яваад хөл, гараа хөлдөөн эд эрхтнээсээ салж сүйд болох нь бий. Шартаж, бөөлжих тухайд арван хүн тутмын тавд нь тохиолдох биз. Ингэж яншсанаараа шинэ жил гээчийг тэмдэглэж болохгүй, энэ баяраас татгалз гэж байгаа юм биш. Бүтэн жилийнхээ амжилт бүтээлийг дүгнэж цэгнэн, амжилттай ажилласан нэгнээ урмын үгээр мялаан, хамт олноороо нэг оройг бужигнаж өнгөрүүлэх нь байх зүйл.

Үргэлжлэл нь III нүүрт

ШҮҮХИЙН ТАНХИМААС



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

## 18 ЖИЛ ДАРАГДСАН ДУУЛИАНТ ХЭРГИЙГ ЗУРГАА ХОНОГ ХЭЛЭЛЦЭЖ, АЛХ ТАСХИЙВ

–С.Зоригийг хөнөөсөн хэрэгтнүүдэд 24–25 жилийн ял оноолоо–

Э.ТУУЛ

Ардчилсан хувьсгалын удирдагч, төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Санжаасүрэнгийн Зоригийн амийг зэрлэгээр хөнөөсөн хэргийн эзэн холбогдогч олдохгүй 18 жилийн турш улстөржиж явсаар өнөөдрийг хүрсэн билээ. Харин түүний эхнэр Д.Булган болон өөр хоёр хүнийг баривчилснаас хойш С.Зоригийн үхлийн хэрэг илрэх нь гэх таамаг мэдээлэл цацагдаж эхэлсэн нь саяхан. Учир нь түүний эхнэр энэ хэргийн цорын ганц гэрч учраас тэр.

Үргэлжлэл нь III нүүрт

ЗАСАГ ДАРГА ЯРЬЖ БАЙНА

## Д.Батлут: ХҮНИЙ ХӨГЖИЛ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТААС ЕРӨӨСӨӨ ХОЦОРЧ БОЛОХГҮЙ

Э.ЭНХ

“Аймгийн Засаг дарга бөгөөд Эрдэнэт хотын Захирагчийн 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2016 оны орон нутгийн сонгуульд МАН-аас дэвшүүлэн оролцсон мөрийн хөтөлбөр, орон нутгийн хэмжээнд хэрэгжиж байгаа бодлогын баримт бичгүүд, нам эвсэл, иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэд, төрийн болон аж ахуйн нэгж байгууллагууд, иргэд сонгогчдын санал үндэслэн боловсруулж хүний амьдралын мөчлөг хүүхэд, залуу, ахмад гурван үеийг хамруулан аз жаргалтай амьдралын төлөө хамтран хэрэгжүүлнэ” хэмээн ярих эрхэм бол Орхон аймгийн Засаг дарга бөгөөд Эрдэнэт хотын Захирагч Д.Батлут юм. Тэрбээр эдүгээгээс 20 гаруй жилийн өмнөөс л Эрдэнэт хоттой ажил, амьдралаа холбож, “Эрдэнэт хивс” ХК-иас ажлын гараагаа эхэлж байсан нэгэн. Түүнчлэн Орхон аймгийн Оюутны холбооны дэд ерөнхийлөгч, “Дэлхийн зөн” ОУБ-ын төслийн гүйцэтгэгч, “Эрдэнэт хамтын хөгжил” ТББ-ын гүйцэтгэх захирал, аймгийн Газрын албанд мэргэжилтэн, Баян-Өндөр сумын Засаг даргын орлогч, Орхон аймгийн НАМЗХ-ын тэргүүнээр ажиллаж байгаад 2008 оноос аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч, аймгийн ИТХ дахь МАН-ын бүлгийн дарга, Орхон аймгийн МАН-ын хорооны дарга гээд бүх шатанд ажиллаж, Орхон аймгийнхаа хөгжлийн төлөө хувь нэмрээ оруулж явсан байдаг. Ийм л түүхтэй хүнийг шинэ оны босгон дээр сониныхоо зочин хойморт залж, ярилцсанаа уншигч та бүхэнд хүргэе.

Үргэлжлэл нь VI-VII нүүрт









| ХААН банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2486.00 | 2496.00 | ФУНТ | 3000.00 | 3104.00 |
| ЕВРО | 2563.00 | 2633.00 | РУБЛЬ | 38.80 | 42.10 |
| ИЕН | 20.96 | 21.30 | ЮАНЬ | 357.00 | 359.90 |

| Худалдаа хөгжлийн банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2482.00 | 2496.00 | ФУНТ | 3018.00 | 3109.00 |
| ЕВРО | 2566.00 | 2646.00 | РУБЛЬ | 39.79 | 42.82 |
| ИЕН | 20.95 | 21.59 | ЮАНЬ | 356.50 | 360.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

БАЙНГЫН ХОРОО

# Ц.СЭРГЭЛЭН: ХИЛИЙН ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ХҮНИЙГ ХАЛАХ, ШИЛЖҮҮЛЭХ АСУУДАЛ БАЙХГҮЙ

Ж.ОТГОН

УИХ-ын Хууль зүйн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороод хамтран хуралдаж, эхлээд Монгол Улсын Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийлээ. Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан асуулт асууж тодруулсан УИХ-ын гишүүн О.Баасанхүү, Л.Болд, Б.Пүрэвдорж нарын асуултад ажлын хэсгийн ахлагч болон Хууль зүй, дотоод хэргийн сайд нар хариулт өгсөн юм.

Ингээд дэгийн хуулийн холбогдох заалтын дагуу ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулахад Байнгын хороодын хамтарсан хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонхи нь дэмжлээ. Тухайлбал, хуулийн дагаж мөрдөх хугацааг зохицуулсан төслийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсгийг "2017 оны хоёрдугаар сарын 01-ний өдрөөс" гэж өөрчлөн найруулахыг дэмжлээ. Энэ саналтай холбогдуулан УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж хуулийн дагаж мөрдөх хугацаа хэт тулгамдуу байгаа юм биш үү, үүний цаана хүний асуудал яригдах учраас дөрөвдүгээр сарын 01 болгох шаардлагатай гэсэн байр суурьтай байгаагаа хэлж байв. Харин энэ талаар төрийнхолбогдохбайгууллагын удирдлагуудын байр суурийг тодруулахад Хил хамгаалах ерөнхий газрын дарга, хошууч генерал Ц.Сэргэлэн "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд хүнийг халах, шилжүүлэх асуудал байхгүй. Хууль хүчин төгөлдөр болох үед хил хамгаалах байгууллагад буцаж ирэх хүмүүст Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу цэргийн цол олгож, зохих албан тушаалд нь ажиллуулна"гэлээ. Харин Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Д.Мөрөн "Хилийн боомтын тухай хуультай холбогдож 400 орчим орон тоо манай байгууллагад шилжиж ирсэн, одоо 200 гаруй ажилтны асуудал бий. Тэдгээр албан хаагчдыг нэр устай нь, цалингийн сантай нь шилжүүлэх юм" гэсэн хариулт өгөв.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Мөн УИХ-ын гишүүн Ё.Баатарбилэг төслийн 48.5 дахь хэсгийг хил хамгаалах байгууллагын хамгаалалтад байгаа обьектод хүч хэрэглэн халдсан, хүч хэрэглэхээр завдсан тохиолдолд галт зэвсэг хэрэглэх агуулгаар өөрчлөн найруулах зарчмын зөрүүтэй санал гаргасан нь хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн дэмжлэг авлаа. Харин хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан УИХ-ын гишүүн О.Баасанхүү, Ё.Баатарбилэг, Ц.Гарамжав, Ж.Энхбаяр, О.Батнасан нарын гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнгүй. Ингээд Монгол Улсын хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төслийг дагалдаж өргөн баригдсан бусад хуулийн төслүүдийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах санал хураалтыг хуулийн төсөл тус бүрээр явуулахад Байнгын хороодын хамтарсан хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонхи нь дэмжсэн юм.

Байнгын хорооны хамтарсан хуралдаанаас уг хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлуулах горимын санал гарган 77.3 хувиар дэмжиж, төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулахаар тогтлоо.

## АН–ын бүлэг хууль тогтоомжийн төслүүдээс завсарлага авлаа

Байнгынхороодынхамтарсан хуралдааны дараа Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дангаараа үргэлжлүүлэн хуралдаж, Дипломат албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх тухай асуудлыг хэлэлцэв. Засгийн газраас энэ сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн уг хуулийн төслийн талаархи төсөл санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил танилцуулсан юм.

Дипломат албаны тухай хуулийг 2000 онд баталсан. Дипломат албаны бодит нөхцөл байдлыг УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2014 оны зургадугаар сард хэлэлцэж, энэ талаар хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх үүргийг Засгийн газарт өгсөн байна. Энэ дагуу Засгийн газраас Дипломат албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулжээ. Дөрвөн зүйл бүхий уг хуулийн төсөлд төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах зорилгоор төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд хилийн чанадад төлөөлөгчийн газраа нээх, төлөөлөгч томилохыг хязгаарлах; Дипломат төлөөлөгчийн газарт томилогдох томилолтын хугацаа гурван жил байсныг дөрвөн жил болгож өөрчлөх, Дипломат төлөөлөгчийн газарт ажиллагсдын нийгмийн баталгааг сайжруулах шаардлагыг харгалзан хилийн чанадад ажиллагсдын цалин хөлсийг гурван жил тутамд Засгийн газраас шинэчлэн тогтоож байх, хүүхдийн цэцэрлэгийн төлбөрийг төрөөс хариуцах, эхнэр буюу нөхөр нь төрийн албан хаагч бол ажлын байрыг нь хадгалах зэрэг зохицуулалтыг тусгасныг салбарын сайд танилцуулгадаа дурдав.Төсөл санаачлагчийн илтгэлтэй холбогдуулан үг хэлсэн УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж гадаад харилцааны чиглэлээр сүүлийн үед яригдаж байгаа асуудлаар Гадаад харилцааны сайдаас мэдээлэл авах шаардлагатай гэж намын бүлгийн хурлаас шийдвэрлэсэн тул Дипломат албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлторуулахтухайхуулийн төсөл, мөн байнгын хорооны энэ өдрийн хуралдаанаар хэлэлцэхээр төлөвлөсөн "Монгол Улсын зарим Элчин сайдын яам, Ерөнхий консулын газар, Консулын газрыг татан буулгах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлаас УИХ дахь АН-ын бүлэг ажлын таван өдрийн завсарлага авах хүсэлт гаргасан юм. Харин байнгын хорооны дарга Ж.Энхбаяр УИХ дахь АН-ын бүлгийн хүсэлтийн дагуу намын тус намын бүлэгт ажлын таван өдрийн завсарлага өгч байгаа, түүнчлэн Байнгын хорооны ирэх оны эхний хуралдаанаар эдгээр хууль тогтоомжийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэхээс гадна сүүлийн үед яригдаж байгаа асуулалтай холбогдуулан Гадаад харилцааны сайдын мэдээллийг сонсоно гэдгийг мэдэгдлээ.

> ...“Засгийн газар Хөгжлийн банк хооронд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй үүссэн 3.2 их наяд төгрөгийн тооцоог 2016 оны арванхоёрдугаар сарын 31-нээр тасалбар болгож байгаа нь ямар учиртай. Зээлийн эргэн төлөлтийг аж ахуй нэгжээс нэхэж авах юм уу” эсэх асуудлыг нэлээд олон гишүүд сонирхож асуусан...

## Хөгжлийн банкны талаар авах арга хэмжээний тухай төслийг дэмжлээ

Эдийн засгийн болон Төсвийн байнгын хорооны хамтарсан хуралдаанболлоо.Хуралдаанаар Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ. Хуралдааны үеэр “Засгийн газар Хөгжлийн банк хооронд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй үүссэн 3.2 их наяд төгрөгийн тооцоог 2016 оны арванхоёрдугаар сарын 31-нээр тасалбар болгож байгаа нь ямар учиртай. Зээлийн эргэн төлөлтийг аж ахуй нэгжээс нэхэж авах юм уу” эсэх асуудлыг нэлээд олон гишүүд сонирхож асуусан. Уг асуудалд ажлын хэсгийн төлөөлөгч “УИХ-аас батлахаар яригдаж буй тогтоолын төслийн нэгдүгээр заалтан дээр Засгийн газар, Хөгжлийн банк хоёрын хоорондох өглөг, авлагын тооцоог нийлүүлэхээр тусгаж өгсөн байгаа. Өөрөөр хэлбэл, Засгийн газар өөрийнхөө нэрийн өмнөөс гадаад зах зээл дээр гаргасан бондын нийт дүн 2.6 их наяд хүрсэн. Энэ мөнгөө Хөгжлийн банкаар дамжуулж, дэд бүтэц, зам барих, үйлдвэрлэлийг дэмжих гэсэн гурван үндсэн чиглэлээр тодорхой төслүүдэд санхүүжилт хийсэн. Нөгөө талд, Хөгжлийн банкны эх үүсвэрийг Засгийн газар зээлэх замаар санхүүжүүлсэн төслүүд бий. Эдгээр төслүүдийн мөнгийг Засгийн газар төсвөөс нөхөн төлөх хэлбэрээр өглөгөө барагдуулахаар зохиуцуулалт хийгдэх юм. Ингээд тооцохоор Хөгжлийн банк Засгийн газарт 2.6 их наяд төгрөгийн өглөгтэй, 3.2 их наяд төгрөгийн авлагатай байгаа юм. Энэ хоёр байгууллага авлага, өглөгөө тооцоолж, блансаа цэвэрлэх зорилгоор УИХ-аас тогтоолын төсөл батлахаар ажиллаж байна” хэмээн хариуллаа. Ингээд зарчмын зөрүүтэй гурван асуудлаар санал хураалт явуулж, хуулийн төслийг дэмжлээ.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.
2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс:
976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

МЭДЭЭЛЭЛ

## Дөрвөн Ерөнхийлөгч шинэ жилийн мэндчилгээ дэвшүүллээ

Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж жил жилийн шинэ жилээр ард түмэндээ өвөрмөц мэндчилгээ дэвшүүлдэг уламжлалтай. Тэрбээр өнгөрсөн шинэ жилээр жүжигчин Дооёогийн хамтаар жүжигчилсэн мэндчилгээ дэвшүүлж байв. Тэгвэл энэ жил Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж өөрийн албан өргөөндөө Монгол Улсын үе үеийн Ерөнхийлөгчид болох П.Очирбат, Н.Багабанди, Н.Энхбаярнарыгурьжхамтарсан мэндчилгээг ард түмэндээ дэвшүүлсэн байна. Тэд шинэ он Монголын ард түмэнд хамгийн сайн сайхан бүхнийг авчирсан жил байхыг ерөөн, мэндчилгээ дэвшүүллээ. Мэндчилгээг Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Алаг дэлхийн бөөрөнд амьдарч байгаа монгол хүн бүрт шинэ жилийн мэнд хүргэж хамгийн сайн сайхныг хүсэн ерөөе” хэмээн өөрийн твиттер хуудаснаа байршуулсан байна.

## Таван генерал зэрэг төрлөө

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж цэргийн дээд цол хүртээх тухай зарлигт гарын үсэг зурсан байна. Ерөнхийлөгчийн зарлигаар ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Даваад дэслэгч генерал цол хүртээхээр болсон бол, Тагнуулын ерөнхий газрын дэд дарга хурандаа н.Дончинбуу, ШШГЕГ-ын дарга Ц.Амгаланбаяр, Хил хамгаалах ерөнхий газрын Захиргаа удирдлага эрхэлсэн орлогч дарга, хурандаа Ж.Бямбасүрэн, Мэргэжлийн удирдлагын газрын дарга, хурандаа А.Лхагвасүрэн нарт тус тус бригадын генерал цол хүртээх болсноор 2016 оны төгсгөлд Монгол Улсад таван генерал нэгэн зэрэг төрлөө.

ШАР МЭДЭЭ

## Засгийн газар утааны голомтод очиж, хуралдах уу



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Утааны эсрэг жагссан ээж, аавууд Засгийн газарт нэгэн шаардлага хүргүүлжээ. Тодруулбал, өнөөдөр болох Засгийн газрын ээлжит хуралдаанаа өргөтгөсөн бүрэлдэхүүнээр буюу Ерөнхийлөгч, УИХ-ын байнгын хороодын дарга нар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороотой хамтран утааны голомттой хэсэг болох Баянхошуунд очиж хийгээч хэмээн шаарджээ. Үнэхээр Ерөнхий сайд, УИХ-ын гишүүд хорт утааг бууруулах тал дээр анхаарлаа хандуулж байгаа бол эцэг, эхчүүдийн саналыг хүндэтгэн үзэж хорт утааны голомтод очиж, хоёр цаг хуралдаж яагаад болохгүй гэж. Өмнөх Засгийн газар асуудалтай газарт очиж, хуралдаж байсан удаа олон бийг энэ Засгийн газрын зарим гишүүд эрхбиш мэдэх байлгүй дээ.

# ҮЗЭЛ БОДОЛ

ШҮҮХИЙН ТАНХИМААС



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# 18 ЖИЛ ДАРАГДСАН ДУУЛИАНТ ХЭРГИЙГ ЗУРГАА ХОНОГ ХЭЛЭЛЦЭЖ, АЛХ ТАСХИЙВ

**–С.Зоригийг хөнөөсөн хэрэгтнүүдэд 24–25 жилийн ял оноолоо–**

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Хуулийн байгууллагын зүгээс албан ёсоор ямар хэрэгт холбогдуулан шалгаж, хорьж байгаагаа тухайн үед мэдэгдээгүй. Тиймээс л үүнийг С.Зориг агсны хэрэгтэй холбон тайлбарлаж байсан хэрэг. Мөн өнгөрсөн хугацаанд Хотын дарга асан Э.Бат-Үүлийг энэ хэрэгт холбогдуулан шалгах болсон нь ч олны анхаарлыг татсан. Энэ мэт улс төрийн зорилго агуулсан, сонгууль бүрийн өмнө С.Зориг агсны хэрэг илэрсэн, эзэн холбогдогч нь тодорхой болсон мэтээр бичдэг байдлыг эцэс болгохоор анх удаа Нийслэлийн прокуророос яллах дүгнэлт үйлдэн, шүүхийн шатанд шилжүүлсэн билээ. Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч М.Алдар энэ хэргийг шүүхээр болж, нэг сарын хугацаанд хавтаст хэрэгтэйгээ танилцсан билээ. Дуулиант хэргийг шүүх хурал 18 жилийн дараа буюу 2016 оны арванхоёрдугаар сарын 14-ний өдөр ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461 дүгээр ангид эхэлсэн.

## Анхны шүүх хурал

**2016.12.14**

Шүүх хурал 10:00 цагт болохоор товлогдсон ч энэ цаг мөчид ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461 дүгээр ангийн гадна хэвлэл мэдээллийнхэн, шүүгдэгчдийн ар гэрийнхэн гээд хүмүүс өглөөний 08:00 цагаас цугларч эхлэв. Түүнчлэн улсын нууцтай холбоотой "Маш нууц" зэрэглэлтэй хэрэг учраас аюулгүй байдлыг хангах үүднээс шалгалтын пост гаргаж, хорих анги руу явж буй иргэн, тээврийн хэрэгслийг нэг бүрчлэн шалгаж байсан юм. Нийслэлийн Прокурорын газраас Ц.Амгаланбаатар, Б.Содномдаржаа, Т.Чимгээ нарын гурван хүнд холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж, ирүүлсэн эрүүгийн хэргийг шүүх бүрэлдэхүүн хурлыг хаалттай хийхээ мэдэгдсэн. Мөн шүүх хурлыг 30 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагын 55 сэтгүүлч сурвалжлахаар хүсэлт гаргасан ч хурлын эхлэл болон төгсгөл хэсэгт камер, хэрэгсэлгүйгээр сурвалжлах боломжтой гэж шийдвэрлэсэн. Түүнчлэн шүүх хурлыг хаалттай явуулах тул утас, камер зэрэг бүх техник хэрэгслийг дотогш нэвтрүүлэхгүй, шүүх хурал болох орчинд гар утасны сүлжээ барих боломжгүй байсан юм. Энэ хэрэгт яллагдагчаар Ц.Амгаланбаатар нарынгурванхүнийгтатсан.Харин улсын яллагчаар Б.Батжаргал, Ж.Сандагсүрэн, хохирогч гэрчээр С.Зориг агсны дүү УИХ-ын гишүүн асан С.Оюун оролцоно гэсэн мэдээлэлтэй байсан ч тэрбээр ирээгүй. 11:30 цагт шүүх хурал эхэлсэн. Шүүх хуралд шүүгдэгч Ц.Амгаланбаатар, Т.Чимгээ, Б.Содномдаржаа нар оролцож байна. Мөн хуралд Ерөнхий шүүгч М.Алдар, Б.Мөнх-Эрдэнэ, С.Оюунчимэг, өмгөөлөгчөөр Л.Мөнхтөр, С.Оюунцэцэг, Д.Дашдорж, Л.Энхсайхан, улсын яллагчаар Б.Батжаргал, Ж.Сандагсүрэн нар оролцож байна. Шүүх хурлыг даргалагч М.Алдар шүүгдэгчдийн холбогдсон хэргийн зүйл ангийг уншиж танилцуулснаар шүүх хурал эхэлж, цааш хаалттай үргэлжилсэн юм. Хурлыг эхлүүлсний дараа хэвлэл мэдээллийнхнийг шүүх хурлын танхимаас гаргав. Дээрх хэргийг улсын нууцтай холбоотой гэж үзсэн тул шүүгдэгчдийн ар гэрийнхнийг хуралд оролцуулах боломжгүй хэмээсэн. Шүүх хурал эхлээд цаг гаруйхан хугацаа өнгөрсний дараа шүүх бүрэлдэхүүн хурлыг хойшлуулах шийдвэр гаргаснаа хэлсэн юм. Өмгөөлөгчид шүүх хурлыг долоо хоногийн хугацаатай хойшлуулах хүсэлт гаргаж, хавтаст хэрэгтэй танилцах боломжийг олгохыг хүссэн аж. Мөн шүүгдэгч болон өмгөөлөгчид нэр бүхий хүмүүсийг шүүх хуралд гэрчээр оруулах санал гаргажээ. Тиймээс шүүх бүрэлдэхүүн хурлыг долоо хоногоор хойшлуулж, энэ сарын 21-ний 11:00 цагт Цагдан хорих 461 дүгээр ангид болохоор шийдвэрлэсэн.

## 2 дахь шүүх хурал

**2016.12.21**

Энэ өдөр Цагдан хорих 461 дүгээр ангийн гадна мөн л хамгаалалт гарч, шүүх хурал 10:50 цагт эхэлсэн. Түүнчлэн хэрэгт маш нууц зэрэглэлтэй материал хавсрагдаж буй учраас олон нийтэд мэдэгдэж болохгүй хэмээж, шүүх хурлыг хаалттай үргэлжлүүлэхээр болж, хэргийн холбогдогчдоос бусдыг нь гаргав. Мөн шүүх хуралд ОБЕГ-ын хоёр шинжээч, сэжигтний ар гэрээс Б.Содномдаржаагийн эгч, гэрчээр Г.Чулуунбат, н.Дааваням гэх хүмүүс оролцож байгаа гэсэн мэдээлэл тухайн үед гарч байв. Шүүх хуралдааны үеэр өмгөөлөгч С.Оюунцэцэгийн даралт ихэссэн тул эмч нар ирж үзлэг хийлээ. Энэ өдөр улсын яллагч Б.Батжаргал, Ж.Сандагсүрэн нар дөрвөн цагийн турш ялын дүгнэлтийг уншиж танилцуулсан. Түүнчлэн өмгөөлөгч нар шүүх хурлыг хойшлуулах хүсэлт гаргасан ч шүүх бүрэлдэхүүн хүлээж авалгүй, сэжигтнүүдээс мэдүүлэг авснаар шүүх хурал үргэлжилсэн юм. 17:42 цагт С.Зоригийг хөнөөсөн гэх Ц.Амгаланбаатар, Б.Содномдаржаа, Т.Чимгээ нарын гурван сэжигтэн мэдүүлэг өгсний дараа энэ өдрийн шүүх хурал завсарлаж, 22-ны өдрийн 10:00 цагт үргэлжлүүлэхээр шийдвэрлэсэн. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 234.2-т "Шүүх хуралдааныг өдрийн цагаар, амрах зайлшгүй шаардлагатайгаас бусад цагт тасралтгүй явуулна" гэж заасны дагуу шүүх хуралдааныг ийнхүү завсарлуулсан.

## 3 дахь шүүх хурал

**2016.12.22**

Цагдан хорих 461 дүгээр ангид С.Зоригийг хөнөөсөн хэргийн шүүх хурал үргэлжлэв. Товлосон цагаасаа 20 минутаар хоцорч эхэлсэн энэ өдрийн шүүх хурал өмнөх өдрийнх шиг л хаалттай үргэлжилж, Г.Чулуунбат, н.Дааваням гэх хоёр хүн гэрчээр мөн л оролцсон. Гэрч Г.Чулуунбатын тухайд хохирогчийн ар гэрийг төлөөлж хуралд оролцож буй бол н.Дааваням нь хохирогч, шүүгдэгчийн алиных нь талаас төлөөлж шүүх хуралд оролцсон нь тодорхойгүй байсан юм. Энэ өдөр шүүгдэгч Ц.Амгаланбаатар, Б.Содномдаржаа, Т.Чимгээ нар дөрвөн цаг орчим мэдүүлэг өгсний дараа улсын яллагч, хохирогч, сэжигтний өмгөөлөгчид шүүгдэгчдэд асуулт тавьж, хариулт авсан. Дундаа нэг цаг завсарласан энэ өдрийн шүүх хурал тасралтгүй үргэлжилсээр 22:00 цаг хүргэж, 23-ны 10:00 цагт үргэлжлэхээр болсон.

## 4 дэх шүүх хурал

**2016.12.23**

Энэ өдрийн шүүх хурал эхлэхэд, өмнөх өдөр нь 10 гаруй гэрчээс шүүх бүрэлдэхүүн мэдүүлэг авсан тухай мэдээлэл ирэв. Гэхдээ гэрчүүд яг хэн байсан, хэдэн хүн нь хохирогчийн ар гэрийг төлөөлсөн, хэд нь шүүгдэгчдийн талаас мэдүүлэг өгсөн бэ гэдгийг эх сурвалжууд хуулийн дагуу нууцалж байсан юм. Гэрчээр оролцож буй н.Дааваням шүүгдэгч Б.Содномдаржаагийн өмгөөлөгчийн хүсэлтээр шүүх хуралд гэрчээр оролцсон тухай мэдээлэл ил болсон. Мөн онцгой байдлын хоёр шинжээч, өөр шинжээчид ч шүүх хуралд оролцож буй гэв. Тэгэхдээ тэд ямар үүрэгтэйгээр нууцын зэрэгт багтсан хэргийг шүүх хуралд суусан нь мөн л нууц. Өмнөх өдрүүдийнх шиг өнөөдөр ч шүүх хурлын хамгаалалт онцгой чанга байв. Энэ өдөр улсын яллагчид шүүх бүрэлдэхүүнд нотлох баримтыг харуулж, хөндлөнгийн шинжээчид хэрэгт холбоотой баримтуудыгшинжлэнсудалсанаа танилцуулсан. Хэрэгт холбогдох нотлох баримтуудыг шинжилж буйг эх сурвалж мэдээллээ. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд 22:00 цагаас хойш шүүн таслах ажиллагааг явуулах боломжгүй гэж заасан байдаг тул М.Алдараар ахлуулсан шүүх бүрэлдэхүүн ажлын цаг дууссан шалтгаанаар хурлыг завсарлууллаа. Хуулийн дагуу ажлын өдөр буюу 26-ны өдрийн 10.00 цагаас шүүх хурлыг үргэлжлүүлэн хуралдуулахаар болов. Эл өдөр 12 цагийн турш шүүх бүрэлдэхүүн 18 жилийн өмнө гарсан хүн амины хэргийн нотлох баримтыг шинжилсэн бөгөөд хэргийн нотлох баримтыг үргэлжлүүлэн шинжлэх шат руу шилжүүлснийг эх сурвалж мэдээлэв.

## 5 дахь шүүх хурал

**2016.12.26**

Шүүх хурал энэ өдөр шүүмжлэлийн шатандаа оров. Энэ нь шүүх хурлын мэтгэлцээний шат эхэлсэн гэсэн үг юм. Тиймээс шүүгдэгч талууд өөр өөрсдийн байр сууриа илэрхийллээ. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд шүүх хуралдааны явцыг нарийвчлан заасан байдаг. Тодруулбал, аливаа Шүүх хурал шүүхийн хэлэлцүүлэг, шүүгдэгчийн мэдүүлэг, хохирогчийн мэдүүлэг, гэрчийн мэдүүлэг, нотлох баримт шинжлэх, шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны шүүмжлэл, шүүгдэгчийн эцсийн үг, шүүх бүрэлдэхүүн тогтоол гаргах гэсэн үе шаттай үргэлжилнэ. Тиймээс шүүх хурал үндсэндээ төгсгөлийн шатандаа орсон бөгөөд шүүгдэгчдийн үгийг сонссоноор шүүх бүрэлдэхүүн шийдвэрээ гаргаж, танилцуулах юм. Энэ өдрийн 20:00 цагийн орчимд шүүх бүрэлдэхүүн шүүгдэгч Б.Содномдаржаа, Ц.Амгаланбаатар, Т.Чимгээ нарын үгийг сонсч дуусаад, шүүх хурлыг 27-ны өдөр үргэлжлүүлэх шийдвэр гаргав.

## 6 дахь шүүх хурал

**2016.12.27**

С.Зоригийг хөнөөсөн хэргийг шүүх хурал өчигдөр 09:00 цагт эхэлж, шүүх бүрэлдэхүүн үргэлжлүүлэн зөвлөлдөж эхэлсэн. Шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөж дууссаны дараа тогтоолоо танилцуулах байв. 11:50 цагийн үед шүүх бүрэлдэхүүн шийдвэр гаргаснаа мэдэгдэв. Шүүх бүрэлдэхүүн шүүгдэгч Б.Содномдаржаад онц хэрцгий харгис аргаар, захиалгаар, бүлэглэн хүний амь нас хөнөөсөн, насанд хүрээгүй хүүхэд уруу татаж, гэмт хэрэгт татан оролцуулсан. Энэ хэргээ нуун далдлах зорилгоор бүлэглэн амь насаа хамгаалах чадваргүйг нь мэдсээр байж хоёр ба түүнээс дээш хүний амь нас хөнөөсөн хэргээр 25 жилийн хорих оноосон байна. Түүнд оноосон 25 жилийн 23 жилийг нь гянданд хорихоор болсон байна. Харин шүүгдэгч Т.Чимэгээд 24 жилийн хорих ял оноолоо. Ц.Амгаланбаатарт давтан хүний амь нас хөнөөсөн, хэргээ нуун дарагдуулах зорилгоор бусдын амь насыг хөнөөсөн үндэслэлээр 25 жилийн хорих ял оноолоо. Шүүх бүрэлдэхүүн прокуророос гаргасан яллах дүгнлэтийг хэвээр нь буюу Эрүүгийн хуулийн 91.2.1, 91.2.4, 91.2.6, 91.2.10, 91.2.11, 91.2.12, 91.2.13, 91.2.15-аар яллажээ. Харин шүүгдэгчдийн ар гэрийнхэн шүүхийншийдвэрийгэсэргүүцэж буйгаа мэдэгдээд давж заалдана хэмээсэн юм. Шүүх хурал хаалттайболсонучраасодоогоор сэжиг таамаг л яригдаж байна. Шүүхийн шийдвэр албан байдлаар баталгаажин талуудад хүргэгдсэнээс хойш хууль зүйн тайлбарууд гарах биз ээ. Ямартай ч 18 жил дарагдсан дуулиант хэргийг зургаа хоног хэлэлцэж, өчигдөр алх тасхийснээр өндөрлөлөө.


# ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2016 оны 12-р сарын 28-ны өдөр**
Тендер шалгаруулалтын нэр: **2017 онд Налайхын Дулааны станц ТӨХК-д хэрэглэгдэх нүүрс нийлүүлэгчийг сонгон шалгаруулах**
Тендер шалгаруулалтын дугаар: **НДДС-2016/Б-03**

**Налайх Дулааны Станц ТӨХК**-ий эрх бүхий тендерт оролцогчдоос **"2017 онд Налайх дүүргийн Дулааны станц ТӨХК-д хэрэглэгдэх нүүрс нийлүүлэгчийг сонгон шалгаруулах"**–ыг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000 төгрөг**, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жилийн буюу 2014, 2015 оны аль нэг жилд борлуулалтын хэмжээ нь 100.0 сая төгрөгөөс багагүй**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **100.0 сая төгрөгөөс багагүй байх**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **2015, 2016 оны хагас жилийн эцсийн санхүүгийн тайлан**

Сүүлийн 1 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **100.0 сая төгрөгөөс багагүй байх**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **"Шаардлагатай"**

Тендерийн хамт 6,750,000 /зургаан сая долоон зуун тавин мянган / төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2017 оны 01-р сарын 27-ны өдрийн 10.00 цагаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 01-р сарын 27-ны өдрийн 10 цагт 30 минутанд** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **"Тооцохгүй"**

Дотоодны давуу эрх тооцох эсэх: **"тооцохгүй"**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 2-р хороо,**
**Найрамдлын гудамж, Налайх дулааны станц ТӨХК-ий байр**
**Утас:7023-2356**


Дугаарын **60** мөр

## Сайхан баярлаарай

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Бас өргөө гэрт нь шинэ хүн мэндэлж, дурлалт хосууд аз жаргалдаа умбан, хэн нэг нь ахуй амьдралаа өөд татан шинэ орон сууцанд нүүн орох гэх мэтчилэн хүний амьдралд од гүйсэн жил болж өнгөрсөн бол эл баярт үйл явдлыг төрөл саднаараа тэмдэглэн, ирэх онд улам илүү амжилт гаргахын ерөөл өргөх нь чухам амьдралыг хөглөж буйн илэрхийлэл буй за. Тиймээс та бүхэндээ сайхан баярлаарай, бага шиг ёолоосой билээ хэмээх гэсэн хэрэг. Оросууд л сэтгэлийн хөөрөлд автдагаараа ёолк тэмдэглэж, зад архиддаг, хот тосгоноороо, ах дүү төрөл саднаараа. Түүнийг нь манайхан 1945 оноос дуурайж, эдүгээ үндэсний баярын хэмжээнд шахам тэмдэглэх болж. Социализмын үед байгууллагууд хамт олноороо банкадласхийгээд л өнгөрүүлдэг байсан бол орчин цагт энэ баяр цар хүрээгээ тэлсээр байгаа. Чухамдаа энэ жил л байгууллага бус ажилтан, албан хаагчид нь өөрсдөө мөнгөө гарган тэмдэглэж байх шиг байна. Эдийн засаг хямарч, эх орон элгээрээ хэвтлээ хэмээн дуу алдах мөртөө аймаг, сумаараа, төгссөн төгсөлтөөрөө, төрийн бус байгууллагуудаараа, фракциараа нийлж дарвисаар, нэгнийгээ магтан хөөргөж, өргөмжлөл жуухаа гардуулсаар байгаа. Охид бүсгүйчүүд гоёлын даашинзны эрэлд мордоцгоон, размер таарахгүй тэвдсэн зарим нь өдрөөр хөлслөн арга үйлээ барж байгаа нь ч бий. Бид ингэж л хөөрдөг ард түмэн. Дэлхийн ихэнх оронд арванхоёрдугаар сарын 25 гэх ганцхан өдөрт ач холбогдол өгч, ах дүү төрөл садан найз нөхөддөө зул сарын мэнд дэвшүүлэн, гэр бүлийн хүрээнд тэмдэглэх аж. Зул сарын "төрсөн нутаг" АНУ-д шинэ жилийг өнгөрүүлж үзсэн тохиолдол миний амьдралд бий. Он солигдох мөчид монголчууд гудамжнаа эсвэл тагтан дээрээ салют, оргилуун дарсыг зэрэг зэрэг буудуулан сүйд болж сүржигнэдэг бол өндөр хамартны нутагт ажин түжин. Гудамж талбай нь эл хуль. Яах вэ, зул сар болдгоороо болоод өнгөрнө. Гагцхүү элэг бүтэн, эрүүл саруул байх явдал билээ. Жилийн жилд л ажлын эхний өдөр баярын өдрүүдэд эрүүлжүүлэгдсэн, амь насаа алдсан гэх зэрэг сэтгэл харанхуйлсан хар мэдээнүүд хөврөх нь бий. Өнгөрсөн жил гэхэд нэгэн сайхан залуу өргөмжлөлөө бариад хөлдөж, амь насаа алдсан дэндүү харамсалтай зүйл Улаанбаатарт гарсан.

Энэ жилийн тухайд сүүлийн 20 жил тохиолдоогүй хүйтэн өвөл болж буйг бид мэдэж байгаа. Ес эхэлж, жавар тачигнаж, хүйтний эрч өдрөөс өдөрт нэмэгдэж буйг хэн бүхэнд сануулахад илүүдэхгүй байх. Албан байгууллагууд ч шинэ жилээ тэмдэглээд бараг л дуусч байгаа байх. Сүүлийнх нь 30-ны өдрөөр төгсгөл болох биз. Гэхдээ амралт залган хэдэн өдрөөр үргэлжилнэ. Газар ойр нь эцэг, эх рүүгээ тэмүүлж, хорт хийнээс зугтаасан нь бяцхан үрсээ аваад ойн зах бараадан алга болдог. Ингэж л ашиглахгүй бол тэр олон өдрийг яаж ч барах вэ дээ, үнэндээ. Гагцхүү ирэх буцах замдаа аюулгүй байдлыг чухалчилж, шинэ онтойгоо эрүүл саруул золговол ирэх жилийн наадам ч ойрхон л байна даа.

# МЭНДЧИЛГЭЭ


"Монголын мэдээ" сонинтой 19 жилийн турш хамт байж урам зориг хайрласаар ирсэн нийт уншигчид, захиалагчиддаа, хамтран ажилладаг байгууллага хамт олонд, шинэ оны баярын мэнд дэвшүүлж, он цагийн тооллоор учран золгож буй 2017 ондоо хиймoрьтой, орчлонгийн сайн сайхан бүхнээр дүүрэн байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье.
"Монголын мэдээ" сонин
www.mminfo.mn сайт

# МЭДЭЭЛЭЛ

## МЭНДЧИЛГЭЭ



Хүн төрөлхтөний шаштирт түүхээ тамгалсан Монгол сайхан эх оронд минь шинэ жил айлчлан ирлээ. Улиран одож буй он АШУҮИС-ийн бүтээлч хамт олны хувьд соён гэгээрүүлэх, сурган хүмүүжүүлэх, судлан шинжлэх, сувилан анагаах үйлсдээ өндөр амжилт гаргасан түүхэн жил болон үлдлээ. Сургалтын хөтөлбөрөө олон улсад хүлээн зөвшөөрүүлж, их сургуулийн сургалтын эмнэлгийн шавыг тавьж, их сургуулийн загвар хотхоны бүтээн байгуулалтаа эхлүүлж, чанарын удирдлагын болон их сургуулийн эмнэлгийн тогтолцоог дээд боловсрол, эрүүл мэндийн салбарт анхлан нэвтрүүлж, судалгаа ба сургалтын уралдаант тэтгэлгийн санг тэрбум төгрөгт хүргэн, судалгааны орчинг олон улсын жишигт ойртуулан, оюутанд ээлтэй сурах, хөгжих орчинг бүрдүүлсэн, гадаад хамтын ажиллагаа өргөжин тэлж үр өгөөжөө өгсөн сайхан жил түүх болон одлоо. Энэ бүх амжилтын үндэс нь АШУҮИС-ийн эрдэмтэн багш, ажилтан, ажилчид, оюутан залуусын хичээнгүй, шаргуу хөдөлмөр, зүтгэл, хамтран ажиллагч дотоод гадаадын байгууллагуудын дэмжлэг туслалцаа хэмээн бид үзэж байна. Айлчлан ирж буй шинэ он хөгжлийн хүрсэн түвшнөө улам баталгаажуулах, сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг ахиулан, үйл ажиллагаагаа улам эрчимжүүлэх, шилдэг, авьяаслаг оюутнуудаа дэмжих, их сургуулийн хөгжилд чанарын өөрчлөлтийг авч ирэх жил байх болно.

**Монгол түмэндээ шинэ жилийн мэндийг дэвшүүлж, аз жаргал, эрүүл энх, амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөе!**

**АШУҮИС-ИЙН ЗАХИРАЛ Г.БАТБААТАР**

*Цаг хугацааны түүх болон үлдсэн хуучин оноо*
*Цаглашгүй их амжилт үйлсээр үдэж*
*Он цагийн тооллоор учран золгож байгаа шинэ жилээ*
*Од хийморь, орчлонгийн сайн сайхан бүхнийг бэлгэдэн угтацгаая.*
*Сайхан баярлаарай*

**Эрчим хүчний яам**

*Ургах ондоо бүтээлээр дүүрэн*
*Урам тэтгэсэн амжилтаар баян*
*Гэгээн гэрлээр гэр тань гийж*
*Гэрэлт оюунаар ухаан тань тэлж*
*Шинэ оноо аз жаргалаар дүүрэн угтаарай*
*Шинэ жилийн баярын мэнд хүргэе.*

**"ДЦС-4" ТӨХК**



*Ширхэглэн бүдрах цагаан цастай*
*Чимэглэн гоёсон ногоон гацууртай*
*Ширээ тойрсон хайртай хүмүүстэй*
*Шинэ оноо сайхан угтаарай*
*Шинэ оны мэнд хүргэе*

**Сүхбаатар дүүргийн Засаг дарга Х.БОЛОРМАА**

## МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсын өнцөг булан бүрт амьдран суугаа нутгийн зон олон Та бүхэндээ айлчлан ирж буй шинэ оны мэндийг айлтган дэвшүүлье. Улиран өнгөрч буй 2016 онд Өвөрхангайчууд та бидний ажил үйлс өөдрөг, сэтгэл тэнүүн, байгаль дэлхий ивээлээ хайрласан буянтай сайхан жил байлаа.

Өвөрхангайчуудын хөдөлмөр зүтгэл, амжилт бүтээлийг төр, засгаас өндрөөр үнэлэн төрийн дээд шагнал Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнагдсан.

Энэхүү эрхэм хүндтэй шагнал нь Монгол улсын төр, Засгийн газрын дэмжлэг, манай аймгийн үе үеийн удирдлагуудын сэтгэл, зүтгэл, хамтын ажиллагаа, нийт ахмадууд, дунд залуу үеийнхэний хөдөлмөр, зүтгэлийн үнэлэмж бөгөөд манай аймгийн бүх ард иргэдийг шагнасан төрийн их хүндэтгэл гэдгийг онцлон тэмдэглэхэд таатай байна. Аймгийн эдийн засгийн гол салбар болсон мал сүрэг өмнөх оноос 700.0 мянга орчим толгойгоор өсч 5.2 сая гаруй толгой малтай болж, мал сүргийнхээ тоогоор улсдаа тэргүүлсэн амжилтаа дахин бататгалаа.

Ирж буй 2017 оныг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр "Ахмадаа дээдлэх жил" болгон зарлаж, энэ хүрээнд ахмадуудынхаа өмнө тулгамдсан асуудлуудыг хамтаараа шийдвэрлэхээр зорилт тавин ажиллаж байна.

Өвөрхангайчууд маань айлчлан ирж буй 2017 ондоо үеийн үед зол жаргалтай, эрүүл энх байж, заяа буян нь өөдрөг байх болтугай.

ЗАСАГ ДАРГА Г.ГАНБОЛД

## МЭНДЧИЛГЭЭ

Дэлхийн болоод Монгол орныхоо өнцөг булан бүрт ажиллаж амьдарч байгаа говьчууд болон уугуул нутгийн иргэд ээ!

Орчлон ертөнц од гаригс цасан гоёлоо зүүж, хоёр он солигдох энэхүү торгон мөчийг тохиолдуулан та бүхэндээ шинэ жилийн баярын чин сэтгэлийн халуун мэндийг дэвшүүлье.

Улиран одож байгаа 2016 он түүхийн шаргал хуудсанд тодоор бичигдэх онцлох үйл явдлаар дүүрэн цаг хугацаа болж өнгөрч байна.

Ард түмэн маань ирэх дөрвөн жилд УИХ болоод аймаг сумын ИТХ-д төлөөлөх төлөөллөө сонголоо. Орон нутгийн сонгуулийн дүнд шинээр томилогдсон аймгийн Засаг даргаас ирэх дөрвөн жилд баримтлах бодлого чиглэлээ тодорхойлж, Өмнөговь аймгийг 2016-2020 онд хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих есөн дэд хөтөлбөрийг боловсруулж батлуууллаа. Бодлого хөтөлбөрт төрийн болон төрийн бус байгууллага, сум, баг, аж ахуйн нэгж, иргэн бүрийн саналыг тусгах ажлыг бүх шатанд олон төрөл хэлбэрээр зохион байгуулж, 3000 гаруй санал гарсныг нэгтгэн боловсруулж төлөвлөсөн нь иргэн бүрийн нутаг орныхоо хөгжлийн төлөө хийе бүтээе гэсэн санал санаачлагыг зохих хэмжээгээр тусгасан говьчууд бидний хамтын бодлого шийдвэр болсонд талархалтай байна.

Бид төрөлх аймгаа хөгжил дэвшилд хүргэж, ард түмнээ сэтгэл хангалуун, амар тайван, элбэг хангалуун амьдралтай болгохыг эрхэм зорилгоо болгон тодорхойлж үйл ажиллагаандаа хамтын удирдлага, эв нэгдэл, ардчилал, шударга өрсөлдөөний зарчмыг баримтлан ил тод, нээлттэй байж, бодлого шийдвэр гаргахдаа иргэдийнхээ хүсэл зоригийг илэрхийлж ажиллахыг ямагт эрхэмлэж байна.

Ирэх 2017 онд аймгийн төр захиргааны байгууллагаас мал аж ахуйн салбарын хөгжлийг эрчимжүүлж, уул уурхай дагасан дэд бүтцийн хөгжлийг дэмжин, нийгмийн салбаруудын үйл ажиллагааны чанар үр дүнг сайжруулах замаар хувь хүний хөгжил, боловсрол, өрх гэр бүлийн амьдралыг сайжруулах бодлого үйл ажиллагааг түлхүү хэрэгжүүлж ажиллах болно.

Золгон ирж буй 2017 он манай аймгийн өрх, иргэн бүрийн амьдралд амжилт бүтээл, аз жаргал, баяр хөөр нэмсэн жил байгаасай гэж хүсэж байна.

Говь нутгийнхаа хөгжил цэцэглэлтийн төлөө бидэнтэй хамтран ажиллаж байгаа төрийн болон төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийнхэн, нийт ард иргэддээ он цагийн тооллоор учран золгож байгаа шинэ ондоо од хийморь орчлонгийн сайхныг бэлгэдэн, эрүүл энх, үйлс бүтэмжтэй, амжилт бүтээл дүүрэн байхыг ерөөе!

**ЗАСАГ ДАРГА Н.НАРАНБААТАР**

## Мэндчилгээ



Хутагт хэмээх эрхэм нэрээр овоглосон Дорноговьчууд бид бүхэн улиран өнгөрч буй оноо амжилт бүтээлийн дээдээр үдэж, айлчлан ирж буй шинэ жилээ цаглашгүй их амжилтын дор угтан авч байна.

Бид хамтын ажиллагаатай улс орнуудтай харилцаагаа улам өргөжүүлэн, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг эрчимжүүлэн Мандах, Хатанбулаг сумдыг төвлөрсөн эрчим хүчинд холбох, Зүүнбаянгаас Ханги хилийн боомт хүртэл төмөр зам барих, Замын-Үүд суманд тээвэр, ложистикийн төв байгуулах, Сайншанд суманд шинээр цэвэрлэх байгууламж барих, иргэдийг хямд өртөгтэй орон сууцаар хангах зэрэг томоохон бүтээн байгуулалтыг эхлүүллээ.

Бидний дундаас паралимпийн хүрэл медальтан, дааамны дэлхийн аварга зэрэг алдар цолтнууд төрөн гарч, аймаг орон нутгийнхаа нэрийг дэлхийн чихнээ цуурайтуулсан жил байлаа. Энэхүү амжилтын бүүхиа цаашид ч тасралтгүй үргэлжилнэ гэдэгт итгэл төгс байна.

Цаашид бид бүхэн хамтдаа хөгжлийн үүд хаалгыг түүчээлэн татаж улс орныхоо нэрийн хуудас болон хөгжих, эхлүүлсэн ажлуудаа дуусгаж үр шимийг нь хүртэх, улам илүү амжилт гарган цэцэглэн хөгжих болно гэдгийг тэмдэглэн хэлэхэд таатай байна.

*Та бүхэндээ шинэ он, шинэ жилийн мэндийг хүргэн аз жаргал, хамгийн сайн сайхан бүхний дээдийг хүсэн ерөөе.*

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Т.ЭНХТҮВШИН

## МЭНДЧИЛГЭЭ

Шинэ оноо угтахаар халуун ам бүлээрээ цуглан, улирч буй оныхоо амжилт ололт, аз жаргалтай дурсамжаа хөөрөлдөн, ирж буй оныхоо хүсэл зорилго, ажил үйлсээ зөгнөн ярилцаж байгаа хоймор нутгийн хийморь золбоот Хөвсгөлчүүд Та бүхэндээ шинэ жилийн баярын мэндийг чин сэтгэлийн ерөөлийн хамт өргөн дэвшүүлье. 2016 он Хөвсгөлчүүд тууштай сонголтыг хамтдаа хийсэн, эрчимтэй хөгжлийн түүчээлэх түүхэн сонголтын жил байлаа. Өнгөрч буй он манай аймгийн хувьд ирээдүйн хөгжлөө тодорхойлсон олон баримт бичгүүдийг боловсруулан хэлэлцэж, батлуулсан хөгжлийн гарааны жил гэдгээрээ онцлог боллоо. Тухайлбал "Хөгжсөн Хөвсгөл-2030" урт хугацааны хөгжлийн хөтөлбөр, аймгийн Засаг даргын "Хөгжлийн хөтөч" 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, хөрөнгө оруулалтын хөтөлбөр зэрэг аймаг орон нутгаа урт болон дунд хугацаанд хөгжүүлэх гол гол хөтөлбөрүүдээ баталж, хийх ажил, хүрэх үр дүнгээ тодорхойлж чадлаа. Цас их унаж цаг үеийн байдал хүндрэх төлөвтэй болсон нөхцөл байдалд урдчилан дүгнэлт хийж аймгийн Засаг даргын хувьд шийдвэр гарган зам даваа хаагдан малчдад өвс тэжээлийн тусламж үзүүлэх ажилд саатахаас сэргийлэн Цагаан-Уул, Улаан-Уул сумын сум дундын өвс тэжээлийн фондыг улсын нөөцийн салбар болгож, нөөцийн өвс тэжээл байршуулсан нь ач холбогдолоо өгч байна.

2016 онд төрийн тулгуур, улсын үндэс болсон шинэ гэр бүлүүд тооноо өргөн, тулгаа тулж, үр тариа, ургац ногоо арвин дэлгэрч, эрдэнэт мал сүрэг саяар өссөн, Хөвсгөл түмэнд минь ээлтэй он болсныг онцлон тэмдэглэе. Хамгаас чухал эрдэнэ болсон олон шинэ хүнээр бүл нэмж аймгийн маань хүн ам 130 гаруй мянга болж өслөө. Хүн нэмбэл хүнс нэмдгийн учир 2016 онд 21408 тн үр тариа хураан авч дотоодын гурилын хэрэгцээгээ 100 хувь өөрсдөө хангаж байна. Мөн 3412 тн төмс, 2071 тн хүнсний ногоо хураан авч дотоодын төмсний хэрэгцээгээ 64, хүнсний ногооны хэрэгцээг 32 хувиар тус тус хангаж өмнөх жилээс хоёр дахин өссөн байна.

Халуунд халж, хүйтэнд хөрч жилийн дөрвөн улирал шаргуу хөдөлмөрлөж байдаг малчид тариаланчдын маань хөдөлмөр бүтээлийн үр дүнд түүхэнд анх удаа таван сая толгой малтай болж улсын хэмжээнд малын тоогоор хоёрдугаар байрт орлоо. Улс, аймгийнхаа нэрийг тив дэлхийд цуурайтуулсан урлаг спортын алдартнуудын амжилт арвин байна. 2016 онд пара Олимпийн хүрэл медаль 1, Дэлхийн аварга 2, Азийн аварга 3 тодорлоо. Спортын өндөр амжилт гаргасан тамирчид, багш дасгалжуулагчдын хөдөлмөр зүтгэлийг үнэлж Засаг даргын захирамжаар 100 сая төгрөгийн урамшуулал олгож тамирчдаа дэмжлээ. Төрийн албаны үйлчилгээг шуурхай, ил тод хүргэх, төрийн албан хаагчдын хариуцлагыг сайжруулах, төрийн үйлчилгээг чанартай хүргэхэд онцгой анхааран ажиллаж байна. 2017 он бүтээснээсээ ихийг бүтээхийн төлөөх чин сэтгэлээр жигүүрлэж "Хөгжлийн хөтөч" хөтөлбөрөө хамтдаан хэрэгжүүлэх эрчимтэй хөгжлийн он болох учиртай.

Эх орны минь гэгээн хоймор үеийн үе, цагийн цагтаа мандан бадрах болтугай. Хөвсгөлчүүддээ шинэ оны мэнд хүргэж, амьдралд нь аз жаргал сайн сайхан бүхний дээдийг хүсэн ерөөе. Хөвсгөлчүүд шинэ жилийн баяраа шинэхэн гацууртай, шинэ амжилтаар дүүрэн угтахыг хүсье.

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Л.ГАНБОЛД**

## МЭНДЧИЛГЭЭ



Дуу хуурын өлгий Дундговь нутгийн зон олондоо болон Монголчууддаа ирж буй шинэ он, шинэ жилийн халуун дотно мэндчилгээг дэвшүүлж, аз жаргал, эрүүл энх сайн сайхныг хүсэн ерөөе.

Хүн бүр хийж бүтээснээ дүгнэн хэлэлцэж, ургах ирээдүйг зөгнөн билгэдэж, ажлаа төлөвлөх чухал бас хариуцлагатай цаг үе билээ. 2016 он та бидэнд урам зориг, амжилт бүтээл, ялалт ухаарлыг зэрэгцүүлсэн сургамж эргэцүүлэл аль алиныг нь үлдээн улиран одож байна.

Өнгөрч буй 2016 онд Дундговь нутгийн минь ажилсаг ард түмний 74 жилийн хөдөлмөр бүтээлийг Монголын төрөөс бахархан үнэлж, Төрийн дээд шагнал "ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН"-т аймгаар өргөмжлөн шагнасан нь бидний түүхэнд тодоор үлдэх бахархам үйл явдал болсныг онцлон тэмдэглэж байна.

Дундговь нутгийн минь ажилсаг, хичээнгүй малчин олны уйгагүй хөдөлмөр, зүтгэлийн үр шимээр орон нутгийн эдийн засгийн үндэс болсон мал сүрэг өсч,гурван саяд хүрсэн бөгөөд улсын болон орон нутгийн төсөв, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрийн эх үүсвэрээр найман тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

2016 оны УИХ-ын болон орон нутгийн ээлжит сонгуулийн үр дүнгээр иргэд, олон түмнийхээ итгэл, дэмжлэгээр миний бие төрөлх Дундговь аймгийнхаа Засаг даргаар томилогдож, 2016-2020 онд аймаг орон нутгаа хөгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөгөө олон нийтийн санал, оролцоотой боловсруулж аймгийн ИТХ-аар батлуулж, орон нутгийнхаа хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоод байна.

2017 он Дундговьчууд бидний хувьд улс төрийн ухаалаг шийдэл, эдийн засгийн эрчимтэй бодлого, нэгдмэл хүч, хамтын хөдөлмөрөөр эдийн засгийн хямралыг даван туулж зорилго, зорилтоо биелүүлсэн, амжилт бүтээлээ ахиулсан баялаг түүхтэй, бахдам амжилттай жил байх болно гэдэгт миний бие итгэл төгс байна.

Та бүхэн минь шинэ ондоо амжилт ололт, аз хийморион дүүрэн байх болтугай.

Дундговьчууд болон Монголчууддаа цог хийморь, амжилт бүтээлийн дээдийг билэгдэн хүсч, эрүүл энх, инээд баясал тэгш дүүрэн амьдрахын ерөөл өргөн дэвшүүлье.

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА О.БАТЭРДЭНЭ**

ЦАГ ҮЕ

ЗАСАГ ДАРГА ЯРЬЖ БАЙНА

# Д.БАТЛУТ: ХҮНИЙ ХӨГЖ ЕРӨӨСӨӨ ХО

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

**-Юуны түрүүнд Орхон аймагт өвөлжилт ямар байна вэ. Цаг үеийн асуудлаас ярилцлагаа эхлэх үү?**

-Та бүхнийг Эрдэнэт хотод хүрэлцэн ирж, манай Орхон аймгийн онцлогтой танилцаж байгаад баяртай байна. Орхон аймгийн хувьд өвөлжилттэй холбоотой асуудлыг тухай бүрт нь судалж, үнэлэлт, дүгнэлт өгч, үйл ажиллагаагаа төлөвлөөд явж байна. Ер нь өвөлжилтийн бэлтгэл ажилтай холбоотой асуудлуудыг бид өнгөрсөн намар нэлээд сайн ярилцсан. Дулааны хангамж, цахилгааны эх үүсвэр гэх мэтчилэн олон асуудлуудаа тал талаас нь ярилцаж, урьд өмнө нь болж байсан бодит хүндрэлтэй байдлуудыг шийдэж ажилласан. Тухайлбал, олон жилийн насжилттай дулааны шугамуудыг засварлах, дулааны эх үүсвэрийг найдвартай хангах боломж бололцоог бүрдүүллээ. Манай Дулааны цахилгаан станц өвлийнхөө нүүрсийг маш сайн нөөцөлж авсан байгаа. Одоогоор 40 орчим тонны нөөцтэй байна. Улирлаараа төлөвлөгөөнийхөө дагуу таталтуудаа хийгээд ажиллаж байгаа. Цахилгаан эрчим хүчээр хангах асуудал дээр бол манай "Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ" ОНӨХК, “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК хамтран ажиллаж байна. Мэдээж, өвлийн горимд шилжихтэй холбогдуулан бүх аваар эрсдлүүдээ хоорондоо ярилцаад нэгдмэл ойлголтод хүрч, засвар үйлчилгээ, тодорхой ажлуудаа зохион байгуулаад ажиллаж байгаа. Тиймээс хүндрэл гарахгүй байх гэсэн бодолтой байна. Нийтийн тээврийн үйлчилгээтэй холбоотой асуудлууд дээр одоогийн байдлаар 4-5 аж ахуйн нэгж ажиллаж байна. Нийтийн тээврийнхэн өдөр тутмын графикийн дагуу үйлчилгээгээ үзүүлээд явж байгаа. Түүнтэй холбогдуулаад гарах эрсдлүүд харьцангуй гайгүй. Бид бүхэн тухайн компаниудын гүйцэтгэлтэй холбогдогдуулан, дээрээс нь иргэдээс ирж буй санал гомдолд тулгуурлаж, нөхөн олговрыг олгодог. Харин иргэдээс санал, гомдол ирсэн, нийтийн тээврийн үйлчилгээг хүргэхгүй байгаа, дутагдал гаргаж байгаа байгууллагуудад тодорхой арга хэмжээ авах, үүрэг чиглэл өгөх хэлбэрээр ажиллаж байна. Цаашид бид нийтийн тээврийн хяналтыг сайжруулах бодолтойгоор төлөвлөж буй ажлууд бий. Үүнээс гадна өвөлжилтийн бэлтгэл ажил дээр яригдах нэг зүйл бол малчдын асуудал. Манай аймаг 130 гаруй мянган толгой малтай. Саяхан мал тооллогоор яваад ирлээ. Манайх улсаас өгсөн төлөвлөгөөний дагуу аймаг, сумын нөөцдөө хангалттай өвс, тэжээлээ татаад авчихсан. Өвөлжилтийн байдал харьцангуй хөдөөдөө хүндрэх төвшинд хүрч, цас, зудын байдалд орчихоод байна. Зарим газарт цасны зузаан 22-27 см байна. Мал тооллогод явсан группүүдээс ирүүлсэн мэдээллийн дагуу дараагийн үйл ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөж байна. Мэдээж өвс тэжээл хангалтгүй бэлтгэгдсэн, худалдан авах шаардлагатай газрууд руугаа бид улсын болон орон нутгийн нөөцөөс өвс, тэжээл хүргүүлэх ажлыг хийнэ. Манай аймагт үйл ажиллагаа явуулдаг Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн удирдлагуудтай ярилцаж, цэргийн штабаараа дамжуулан жанжин штабд хүсэлт өгсний дагуу бид бүхэн яг ослын үед буюу өвөлжилт хүндэрсэн үед гаргах туулах чадвар сайтай 10 машиныг бэлэн байдалд оруулчихаад байна. Энэ дагуу бид тэжээлүүдийг нь ачаад явуулах боломж бололцоог бүрдүүлээд ажиллаж байна. Сүүлийн үед цас орох нь харьцангуй гайгүй байгаа. Тэгэхдээ жаахан дулаарахаар цас хайлалт явагдаж байгаа учраас цас суух, мөстөх, нягтаршил ихсэх нөхцөл байдал үүсч байна. Бид тухай бүрт нь тодорхой арга хэмжээ авч, ажиллана.

**-Та ажлаа аваад таван сар гаруйн хугацаа өнгөрсөн байна. Ажлаа авах үедээ ямаршуухан эдийн засгийн чадамжтай аймаг хүлээж авав. Цаашид ямар ажил хийхээр төлөвлөж байна?**

-Бид бүхэн ажлаа аваад таван сар гаруй хугацаа өнгөрч байна. Төсөв мөнгөний хувьд хүндрэлтэй байсан. Үнэхээр Монгол Улсын эдийн засаг хүндэрчихсэн, одоогийн нөхцөл байдал илааршаагүй, дэвшил гарсан зүйлүүд бага байна шүү дээ. Тэгэхээр бид бүхний нөхцөл байдал ч адилхан байгаа. Улсын төсөв ямар байна, бид тийм л байна. Нэг ёсондоо нэг халааснаас бид санхүүжиж, бүх үйл ажиллагаагаа зохицуулж байгаа болохоор уялдаад байгаа юм. Тэгэхдээ орон нутгийн зүгээс бодит нөхцөл байдлыг харж, эдийн засгийнхаа нөхцөл байдлыг сайжруулах талаар тодорхой алхмуудыг авч хэрэгжүүлж байна. Богинохон хугацаанд үр дүн гарах боломжгүй учраас хэлэхэд хэцүү байна. Гэхдээ үр дүн гарна гэсэн итгэл найдвар байгаа.

**-Аймгийн ИТХ-ын хуралдаанаар Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөг баталсан. Энэхүү хөтөлбөр, төлөвлөгөөнд ямар асуудал голлох байр суурийг эзлэж байна вэ?**

-Бид бүхэн саяхан аймгийн ИТХ-ын III хуралдаанаар аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөг баталлаа. Үндсэндээ 2017 оны үндсэн чиглэл, хийж хэрэгжүүлэх ажлын үндсэн төлөвлөгөөгөө баталчихсан гэсэн үг. Засаг даргын мөрийн хөтөлбөрөө ч мөн батлууллаа. Бид ирэх жилүүдийг хүний хөгжлийг түргэтгэх хэлбэр рүү анхаарч, хүний хувьсан өөрчлөгдөх явцыг дэмжсэн он жилүүд болгоно гэсэн төлөвлөгөөтэй байна. Ер нь аливаа бүтээн байгуулалтад маш том том хөрөнгө оруулалт хийгдээд байдаг. Угтаа бол хүний хөгжил бүтээн байгуулалтаас хоцорч болохгүй. Яагаад гэвэл нийгмийн капитал нь хүн өөрөө. Тийм учраас энэ том бүтээн байгуулалт дотроос хүний хөгжил ерөөсөө хоцорч болохгүй. Хүний хөгжлийг бид түлхүү тавьж өгч байж энэ нийгэм урагшилна. Илүү их бодитой хөрөнгө оруулалт бий болно. Нийгмийн тогтолцоо ч хариуцлагажина. Тэр чинээгээрээ хөгжлийн төвшин шат ахина. Нийгэмд эзлэх байр суурь ч тодорхой хэмжээгээр сайжирна гэж харж байгаа. Тэгэхээр бид ирэх оны төсөвт хүний хөгжилтэй холбоотой асуудлуудыг нэлээд түлхүү тавьж өгсөн. Тодруулбал, нийт төсвийн маань 22 хувь нь дээрх төсөл, хөтөлбөрүүдэд тусгагдаж байгаа. Энэ дотор хүн рүүгээ чиглэсэн тодорхой ажлуудыг хийхээр төлөвлөсөн. Харин төсвийнхөө үлдсэн хэсгийг хөрөнгө оруулалтын ажилд зориулж байна. Гэхдээ бид том бүтээн байгуулалт гэхээс илүү хүний амьдралын төвшинд нөлөөлж байгаа ямар асуудлууд байна. Тэр бүхнийг шийдэхийн тулд бид үйл ажиллагаагаа чиглүүлэн явуулна.

**-Тухайлбал, яг одоо тулгамдаж буй ямар асуудлууд байна вэ?**

-Жишээ хэлэхэд, манай Орхон аймагт орон сууцны дээврийн асуудал хүндээр тавигддаг. Байнга л асуудал дагуулж байдаг. Мэдээж хүний хөгжил ярьж л байгаа бол бид хүн бүрийн аюулгүй, амгалан тайван, эрүүл орчинд амьдрах бололцоог нь хангах ёстой. Ажилтай, орлоготой болгох ёстой. Олон талаас нь бодох ёстой учраас бид тэр асуудлуудыг эхнээс нь нэг мөр шийдье гэсэн бодолтойгоор төсөв төлөвлөгөөндөө тусгаад явж байгаа.

**-Ажилтай, орлоготой болгох ёстой гэлээ. Орхон аймагт ажилгүй иргэн хэчнээн байна вэ. Тэдгээрийг хэрхэн ажлын байртай болгох вэ?**

-Ажилтай, орлоготой болгох асуудлууд ирэх оноос яригдана. Ер нь миний дэвшүүлэн тавьж байгаа гол асуудал бол судалгаан дээр үндэслэж, аливаа зүйлийг хийх. Тухайлбал, Батболдынх гэж айл байхад таван ам бүлтэй. Тэгвэл Батболдынх гэдэг айлаас нэг ч хүн хөдөлмөр эрхлэхгүй байна уу, үгүй юу гэдгийг судалж үзсэн. Судалгаагаар тухайн айл өрхөөс нэг ч хүн хөдөлмөр эрхэлдэггүй 2832 өрх гарч ирж байна. Нийгэмд болж байгаа сөрөг үзэгдлүүд энэ зүйлүүдээс гараад байгаа байхгүй юу. Ажилгүй, орлогогүй байгаа байдал. Тэгэхээр энэ бол онцгойлон авч үзэх ёстой арга хэмжээ. Тэр утгаараа бид судалгааны дагуу ажил зохион байгуулахаар хэлтэс, агентлагуудтайгаа ажиллаж байна. Эндээс бид ядахдаа нэг хүнийг ажилтай болгоё. Тэгвэл тэр хүмүүсийн өнөөдрийн нийгмийг харах өнцөг нь өөр болно. Тэр гэр бүлийн байнгын мэдээллүүд дунд нэг өөр өнцөг орох байхгүй юу. Тэр чинээгээрээ хүмүүс нийгмээ зөвөөр үнэлж харах, өөрсдийнхөө бодит боломжийг илэрхийлэх идэвхтэй мотиваци хийгдээд явчих юм. Тийм боломж бололцоо ч харагдаж байна. Энэ бол нөгөө л хүний хөгжил рүү орох гээд байгаа хэлбэр шүү дээ. Нэг ёсондоо өнөө, маргаашийн хоолоо яриад явж байгаа хүмүүсийн дунд орлого нэмэгдээд, нийгмийн тодорхой мэдээллүүд ороод ирэхээр тэр хүмүүс нийгмийг шал өөрөөр хардаг, орчин нөхцөлдөө санаа тавьдаг бас амьдралыг харах өнгө аяс нь өөр болно гэж харж байгаа юм. Тэр утгаараа бид энэ тал руу чиглэсэн ажлуудыг нэлээд сайн зохион байгуулахаар төлөвлөсөн. Ингэснээрээ нийгэмд гарч байгаа сөрөг үзэгдлүүд буурах боломжтой. Энэ арга хэмжээнүүдийг төлөвлөөд ороход олон асуудал байна л даа. Мэдээж бид ажлын байрыг яаж бий болгох вэ гэдэг асуудал байгаа. Бидэнд боломж бий, санаачлаад хийх юм бол. Жишээлбэл, эргэн тойронд малчид байна. “Малаа дийлэхгүй байна, туслах малчин авъя. Аравдугаар сараас дөрөвдүгээр сар хүртэл сарын 600 мянган төгрөгөөр цалинжуулъя. Өвлийн идшийг нь даая” гэсэн маш олон хүн байна. Үүнийг л бид жижигхэн зохион байгуулалтад оруулаад өгчих хэрэгтэй. Дээрээс нь манай Эрдэнэт хот боловсон хүчний илүүдэлтэй газар. Тэгэхэд бусад аймгуудад дутагдалтай нь юу байна. Багш, эмч дутагдаж байна уу. Тэр судалгааг авч байгаад бид тухайн мэргэжлийн хүмүүсийг явуулах талаар орон нутагтай зарчмын хувьд тохиролцоно. Тухайлбал, орон сууц, байраар хангах, түлээ түлш, мал таслаж өгөх гэдэг ч юм уу. Нийгмийн асуудлыг шийдээд явуулчих бололцоо байна гэж харж байгаа юм. Наад захын асуудал нь энэ. Мөн бид хувийн хэвшилтэй холбоотой нэлээд зүйлийг өөрчлөе гэж харж байгаа юм. Өнөөдөр вакум цонхны үйлдвэрлэл гэж байна. Эрдэнэтэд үйлдвэрлэл эрхэлж байгаа, хувийн бизнес эрхэлж байгаа маш олон хүн бий. Тэгвэл энэ хүмүүсийн чадамж нь хэр байгаа юм бэ. Хүчин чадал нь хэр юм. Дээрээс нь чанар, стандартын шаардлага хангаж байна уу. Тэр бүх зүйлийг тодорхой болгоод бид он гаргаад зөвлөгөөн хийнэ. Бүх асуудлуудыг нь тодорхой болгочихоод орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа бизнесмэнүүдээ дэмжиж өгье. Жишээлбэл, энд нэг барилга барьж байгаа компани байх юм бол гэрээн дээр нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа чанар стандартад нийцсэн аж ахуйн нэгжээс вакум цонхыг нь авна гэдэг ч юм уу. Ерөөсөө л энэ. Нэг үгээр хэлбэл, орон нутагт хийж байгаа бизнес дээр орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг оруулж өгөх юм. Ингэснээр тэр хүмүүсийн орлого нэмэгдэх, тэр дагуу ажлын байрыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх, орон нутагт орж байгаа төлбөр нь нэмэгдэх, санхүүгийн талыг сайжруулах талаар авч байгаа арга хэмжээний нэг хэлбэр нь энэ байхгүй юу. Гэх мэтчилэнгээр ажиллая гэсэн бодолтой байна.

**-Анх удаа Засаг даргын дэргэдэх “Эрдэмтдийн зөвлөл” байгуулагдсан талаархи мэдээлэл цацагдаж байсан. Тэр нь танай аймаг байсан л даа. Энэ талаар тодруулахгүй юу?**

-Бид их том зорилт тавьж байгаа. Тодруулбал, эрдэмтдийн бүтээлийг орон нутгийн хөгжил, бүтээн байгуулалтад нэвтрүүлэх зорилгоор Засаг даргын дэргэдэх “Эрдэмтдийн зөвлөл”-ийг байгуулж, аймгийн ИТХ-аар батлуулсан. Түүнчлэн “Эрдэнэт шинжлэх ухааны технологийн парк”-ийг шинээр байгуулж байна. Энэ бол Монгол Улсын хэмжээнд анх удаа хийгдэж буй ажил. Өнөөдөр бидний алсын хараа юу юм бэ, түүндээ хүрэхийн тулд бид яах ёстой юм гэвэл манай Эрдэнэт өөрөө их оюунлаг газар. Оюуны чадавхи өндөртэй. Энэ хүмүүсийнхээ толгойг ашиглая л даа. Нэг ёсондоо бид шинжлэх ухаанчаар чиг шугамаа тодорхойлъё гэсэн л санаа. Хоёрдугаарт, “Эрдэнэт” үйлдвэр хэзээ нэгэн цагт ашиглагдаад дуусна. Одоо 40 гаруй жил болчихлоо. Нэг ёсондоо ашигт үйлийн коэффицентууд нь нэлээд доогуур орчихсон байна. Баяжмал дотор байгаа агуулгын хэмжээ буураад байгаа гэсэн үг. Тэгвэл энэ үйлдвэр зогслоо гэхэд эрдэнэтчүүд бид яаж амьдрах ёстой юм бэ. Энэ асуудал биз. Өнөөдөр 6000 гаруй хүн яг энэ үйлдвэрт ажиллаж, эндээс амьдралаа залгуулж байна. Зарим нэг уурхай дагасан хотуудын жишээ байдаг шүү дээ. Уурхай зогслоо хот эзэнгүй болдог. Тэгвэл бид энэ сайхан зууны манлай бүтээн байгуулалт, үйлдвэрийг дагаж бий болсон хотыг яг энэ хотоор нь улам цааш нь эрчимтэй хөгжүүлэх шаардлагатай байгаа юм. Тийм учраас бид “Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк”-ийг байгуулж байгаа юм. Энэ парк ямар үйл ажиллагаа явуулах вэ гэвэл хүмүүсийг боловсруулах, мэдлэгжүүлэх, оюуны чадавхийг нэмэгдүүлэх тал дээр анхаарч сургалтад ашиглагдана. Хоёрдугаарт, үйлдвэрлэлийн чиглэлээр шинэ дэвшилтэт технологийг бий болгох чиглэлээр ажиллана. Үйлдвэр дууслаа гэхэд бид шинэ технологийг бий болгочихсон, томоохон эдийн засгийн төв болсон байх ёстой. Үүний цаана хүмүүс толгойгоо үнэлж амьдардаг, эрдэмтдийн оюуны чадавхийг дэлхийн төвшинд үйлдвэрлэе гэсэн санаа явж байгаа юм. Ингээд бид 2017 ондоо ямар ч байсан нэг үйлдвэр байгуулъя гэж бодож байгаа. Мэдээж хувийн хэвшилтэй хамтарч ажиллана. Эхний ээлжинд юу хийх вэ гэвэл “Эрдэнэт” үйлдвэрт хэрэглэгдэж байгаа гаднаас импортоор орж ирдэг бараа бүтээгдэхүүнээс өөрсдийн хэмжээнд судална. Судалгааны дунд манай эрдэмтдийн санаачилсан төслүүд гараад ирэхийг үгүйсгэхгүй. Тэр бүх зүйлийг нэгтгэж байгаад “Эрдэнэт” үйлдвэрт импортоор нийлүүлж байгаа бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийг эхлээд байгуулчихна. Үйлдвэр байгуулъя, технологийг нь бид өөрсдөө бий болгоно гэсэн үг. Тэнд нь хувийн хэвшилтэй хамтраад хөрөнгө оруулалт хийчихье. Тэгээд “Эрдэнэт” үйлдвэр худалдаж авдаг байя. Энэ юу гэхээр гадагшаа урсаж байгаа валютын нөөц тодорхой хэмжээгээр Эрдэнэтдээ үлдэнэ гэсэн үг. Нөгөө эдийн засгийг сайжруулах нэг түлхүүр чинь энэ. Нөгөө талдаа цаашдаа бид импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс гадна экспортын чиг баримжаатай болъё. Нэг ёсондоо бүтээгдэхүүнээ бүтэн гаргая гэсэн санаа байгаа юм. Магадгүй Samsung, Iphone гээд гар утас үйлдвэрлэгч компаниудын нэг деталыг бид бэлдэж болно шүү дээ. Магадгүй тэднээс давсан шинэ зүйлийг гаргаад ирэхийг ч үгүйсгэхгүй шүү дээ. Энэ бүхэн тэгэхдээ урт хугацааны маш том зорилт юм. Энэ бүхнийг хүмүүст бид их зөвөөр ойлгуулж таниулах ёстой гэж бодож байгаа. Ингээд ирвэл шинжлэх ухаан дээр тулгуурласан оюуны чадавхийг худалдсан томоохон эдийн засгийн бүс болох, хот болгох зорилт маань биеллээ олно гэсэн үг. Энэ ажлын маань эхлэл болгож, “Эрдэнэт шинжлэх ухааны парк”-ийн ТУЗ-ийг нэгдүгээр сард батлана. Захирал нь ч томилогдоно. Үүнд улс төр байхгүй, дандаа эрдэмтдийн баг ажиллана. Би дэргэдээ “Эрдэмтдийн зөвлөл” байгуулаад шууд шинжлэх ухаан технологийн парк дээрээ аваачиж байгаа юм. Эндээ бид ГОК-той холбогдоно. Шинжлэх ухаан технологийн их сургууль гэж технологийн бааз суурь өндөртэй газар байна. Түүнтэйгээ хүч хавсарна. Химийн лабораториуд, бусад бүх байгууллагуудыг “Эрдэнэт” үйлдвэртэй хамтран ажиллах гэрээний хувьд энэ шинжлэх ухаан технологийн парктайгаа уяж өгөх гээд байгаа юм. Ингээд цаашаа том хөтөлбөр, нэг цикль хөдлөх гээд байна шүү дээ. Тэр чинээгээрээ орон нутагт орж байгаа төсвийн орлого нэмэгдэнэ. Ажлын байр нэмэгдэнэ, хүн ажилтай болно. Ер нь нэг иймэрхүү байдлаар ажилгүйдэл, эдийн засгийн нөхцөл байдлыг сайжруулах чиглэлээр ажиллана гэж бид зорьж байна.

**-Гадаадын төсөл хөтөлбөрүүд орон нутагт нэлээд үр дүнгээ өгч байгаа харагддаг. Өөрсдийнхөө боломж нөөц дээр нэмээд орон нутагтаа гадны төсөл хөтөлбөрүүдийг татаж чадвал бүр илүү хөгжих боломж байгаа юм шиг санагдах юм?**

-Тэгэлгүй яах вэ. Тухайлбал, Бүгд найрамдах Чех улсын “Евро эко” төсөл гэж байгаа. Тэд дөрвөн улирлын хүлэмжийн аж ахуй байгуулъя. Хүмүүсийг чинь сургаж өгье гэдэг санал тавьж байна. Энэ төсөл дээр ажиллавал хүмүүсийг тодорхой ажилтай болгох нөхцөл боломж байна. Мөн би саяхан Герман улсад ажлын айчлал хийгээд ирсэн. Энэ хүрээндээ “Эрдэнэт” үйлдвэрийн бааз, суурийг ашиглаад уул уурхайн тоног төхөөрөмжийг угсрах үйлдвэр байгуулах гэж байна. Төслөө танилцуулчихаад ирлээ. Ерөөсөө Европын брэндүүд яагаад ийм үнэтэй байдаг юм бэ гэвэл тэд цагийн үнэлгээгээр явдаг. Нэг цагийн тэд, тэдэн евро гээд л явчихдаг. Манайд харьцангуй ажиллах хүчний зардал бага шүү дээ, үнэлгээ багатай. Гэхдээ тэр сэлбэгүүдийг авч ирээд угсрах учраас чанарын хувьд адилхан. Тодорхой хэмжээгээр өртөг буурна. Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд бодлогоор тэр төхөөрөмжийг хийдэг байх ёстой. Энэ нь дотоод зах зээлээ хадгалж байгаа нэг хэлбэр төдийгүй Монголын эдийн засагт өгөөжтэй төсөл гэж ойлгогдож байгаа юм. Зөвхөн Эрдэнэт ч биш Монголын эдийн засагт өгөөжөө өгөх учиртай. Дээрээс нь Сокол гэж компани манайд үйл ажиллагаа явуулж байгаа. Галын тусгай хэрэгслийн автомашин, тоног төхөөрөмж нийлүүлдэг. Энэ компанийнхан бидэнд санал тавьж, галын тоног төхөөрөмж, машиныг үйлдвэрлэх үйлдвэр байгуулъя гээд байгаа юм. Би тэгвэл газрын асуудлыг нь шийдээд өгье, энд байгуулчих гэж байгаа. Хамгийн гол нь зах зээл нь байгаа юм. Монгол Улсын аваар ослын 90 орчим хувь нь гал түймэртнй холбоотой. Гэтэл хуучин хэрэглэгдэж байсан тоног төхөөрөмжүүд чанарын шаардлага хангахгүй болоод шинэ тоног төхөөрөмжийн хэрэгцээ гарч ирнэ. Тэр хэрэгцээг бид хямд үнээр шийдье гэж байгаа юм. Дээрээс нь ажлын байр бий болно. Цаашилбал ОХУ-ын зүүн талын хэсгээр бидэнд маш өргөн зах зээл байна. Нэг үгээр хэлбэл, ажлын байр нэмэгдүүлье, Эрдэнэтийн болон Монголын эдийн засгийг өсгөе гээд олон тал руу харсан төслүүдийг хөдөлгөе гэсэн бодолтой байна.

**-Хог боловсруулах үйлдвэр байгуулах талаар дуулдсан. Хогийг ч мөнгө болгох бодолтой байна уу?**

-Хоёр дахь том төсөл маань хог боловсруулах үйлдвэр. Манай Эрдэнэт бол байгуулагдсан цагаасаа л дандаа ил задгай хогоо хаяж байсан. Өөрөөр хэлбэл, байгальд шууд хаяж байсан. Одоо таван хогийн цэг дүүрээд, маш их хогтой болчихсон. Үнэндээ хэцүү байгаа л даа. Өдөрт 600 м3 хог хаяж байна. Үүнийг яаж үр өгөөжтэй байдлаар шийдэх вэ гэдэг төслийг манай эрдэмтдийн багийнхан боловсруулсан. Тэгээд сая Германд айлчлах үеэрээ танилцуулсан. Ер нь үр дүнтэй, бүтэх байх гэж бодож байна. Хог боловсруулах үйлдвэр байгуулахдаа бид тодорхой орлоготой, эх үүсвэртэй байх талаар анхаарч байгаа. Өөрөөр хэлбэл, хогоо боловсруулаад тэндээс юу хийх вэ гэвэл гудамжны сандлууд, траншейны тагуудыг хийж болж байна. Мөн эрчим хүч үйлдвэрлэж болж байна. Тэр бүх төслүүдийг бид цогцоор нь танилцуулчихсан байгаа. Дараагийн нэг төсөл бол бид газрын дулааныг ашиглаад эрчим хүч гаргах. Энэ бол маш ирээдүйтэй төсөл. Манайд газрын байршлын хэлбэрээр 80-100 метрийн гүнээс газрын дулааныг ашиглах бололцоо байна гэж харж байгаа юм. Ингэвэл эрчим хүчний хэмнэлтийг бий болгож чадна. Бүр гэр хорооллын асуудлаа ч шийдчихнэ. Гэр хорооллын асуудлаа шийдчихвэл утаанаас сална. Иймэрхүү төслүүдийг боловсруулаад гадна, дотны байгууллагуудтай хамтраад ажиллаж байна. Томоохон төсөл хөтөлбөрүүдтэй зэрэгцээд бид өрхийн бизнес эрхлэгчдээ дэмжих ёстой. Өнөөдөр өрхийн бизнес эрхэлж байгаа хүмүүс банкны шалгуурт уначихаад, зээл авч чаддаггүй. Үнэндээ 1-2 сая төгрөгийн асуудал л яригддаг. Тэгэхээр нэг тусдаа сан байгуулъя гэж байгаа юм. УИХ-ын даргад ч энэ асуудлаа тавьсан. Ерөнхий сайдад ч хэлсэн байгаа. Монгол Улсын Засгийн газрын төлөвлөгөөнд орсон. Өрхийн бизнес эрхлэгчдэд “Итгэлийн зээл” олгох асуудал. Одоо хууль эрх зүйн тогтолцоог нь бий болгоод өгчихвөл зээлийг нь олгох боломж бололцоо нээгдэнэ. Тэгвэл 10 хүнийг нэг групп болгоод дундын сан үүсгээд барьцаагүй зээл олгоно гэсэн үг. Тэгээд тэр хүмүүс орлогоо нэмэгдүүлдэг, ажлын байр нэмдэг. Энэ ажлыг ирэх оноос хийж, хэрэгжүүлэхээр зорьж байна. Би Дэлхийн зөн олон улсын байгууллагад ажиллаж байхдаа ББСБ-ыг үүсгэн байгуулж байсан хүний нэг. Тэгэхээр энэ итгэлийн зээлийг яаж гаргадаг технологийг сайн мэддэг. Тухайлбал, бие биеэ мэддэг 5-10 хүн нэгдээд, дундаасаа ахлагч, нягтлан, нярваа томилоод, дундын сан үүсгээд сар болгон мөнгөө нэмээд явна. Үүний зэрэгцээ сургалтууд авч, өөрсдөө төслөө бичээд түүнийхээ дагуу зээлээ авдаг. Хэрвээ би зээл авч байгаа бол нөгөө гурав нь намайг батлан даадаг. Энэ хүн зээлээ төлөхгүй нөхцөлд нөгөө гурав нь батлан даадаг. Эсвэл дундын сангаасаа шийднэ гэдэг ч юм уу. Ийм зарчмаар явж чадвал хүмүүс ойртож, тэр чинээгээрээ амьдрах итгэл бий болно. Бизнесийн нөхцөл байдал ч сайжраад ирнэ. Нэг жишээ хэлэхэд, Баянцагаан багийн I дүгээр байр гээд 20 орчим айл байдаг юм. Би тэр айлуудаар орж, нөхцөл

> ...Хамгийн гол нь зах зээл нь байгаа юм. Монгол Улсын аваар ослын 90 орчим хувь нь гал түймэртнй холбоотой. Гэтэл хуучин хэрэглэгдэж байсан тоног төхөөрөмжүүд чанарын шаардлага хангахгүй болоод шинэ тоног төхөөрөмжийн хэрэгцээ гарч ирнэ. Тэр хэрэгцээг бид хямд үнээр шийдье гэж байгаа юм. Дээрээс нь ажлын байр бий болно...

# ЖИЛ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТААС ОЦОРЧ БОЛОХГҮЙ




байдалтай нь танилцсан юм. Намайг очих үед байр нь навсайчихсан, бие засах газар, угаалтуур байхгүй. Ороход өмхий үнэртсэн, нурж унах гэж байгаа тийм л газар байсан. Тэгээд аймгийн зардлаас 13 сая төгрөг гаргаж байгаад тэр байрыг засварлуулсан. Одоо сайхан болсон байгаа. Би тэндээс нэг л зүйлийг олж харсан. Намайг анх очиход навсайсан байранд нэг л нурамгар хүмүүс, ямар ч амьдрах итгэлгүй хүмүүс тэнд байсан. Тэгээд засвар хийгээд гоё болгоод айл болгоныг ариун цэврийн өрөөтэй болгоод, цэвэр усыг нь оруулаад өгсөн. Одоо очихоор үнэхээр сайхан болголоо, бид үүдээ цэвэрлэчихсэн гээд л эргэнтойрноосайханцэвэрлэчихсэн байгаа байхгүй юу. Бүр жижүүр гаргаад коридороо цэвэрлэнэ гээд л. Ийм л байх ёстой байхгүй юу. Би тэр хүмүүсийн харцнаас амьдрах итгэлтэй байгааг нь олж харсан. Урьд нь харагдаж байсан нүүр төрх, харц шал өөр болчихсон. Тэгэхээр бид ийм байдлаар хүмүүст нөлөөлж, орчин нөхцлийг нь сайжруулаад, асуудлуудыг цогцоор нь шийдээд явчих юм бол хүний хөгжлийг бодох ажлууд маань нэлээд үр дүнгээ өгнө гэж харж байна. Ер нь бол хүмүүсийн харц, идэвх шал өөр болчихдог юм шүү. Бид жижигхэн хөдөлгөөд өгчихвөл хүмүүс өөрчлөгддөг. Асуудлыг энэ мэтээр шийдээд явчих бүрэн боломж байна.

**-Одоохондоо Эрдэнэт Улаанбаатарыг бодвол утааны асуудал харьцангуй гайгүй байна. Яг энэ үед буюу утаа бага байгаа дээр нь дарж авах тал дээр ямар ажлуудыг хийж байна?**

-Дараагийн асуудал бол утаа. Урьд нь утааны асуудал, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр олон төсөл хэрэгжиж байсан л даа. Сайжруулсан зуух, хоёр тарифт тоолуур, хийн хэрэглээ гээд арга хэмжээ авч байсан. Яг энэ технологиудыг бид хэрэглээд явж байгаа. Хоёр тарифт тоолуурыг тавилаа гэхэд шөнө цахилгаанаар гэрээ халааж байгаа нөхцөл манайд байхгүй. Тийм чадамжтай иргэн ч цөөхөн. Би зүгээр хийгдэж байгаа ажлыг шүүмжлээд байгаадаа гол нь биш л дээ. Бодит хөрсөн дээрээс ярьмаар байгаа юм. Яг яаж өөрчлөх ёстой юм бэ гэдгийг. Тэгэхгүй бол бид нэг юм шийдчихдэг. Нөгөөдөхөө ашиглаж чадахгүй бол ямар ч үр дүн гарахгүй. Зуух бол байж болно гэж харж байгаа юм. Ерөнхийдөө утааг юу гаргадаг юм бэ гэвэл түлш л биз дээ. Тэгвэл бид түлштэйгээ л ажиллах хэрэгтэй. Өнгөрсөн намар бид судалгаа хийсэн. "Шарын гол" компанийн нако системийнхэнтэй очиж уулзсан. Нако түлш гэж нэг ёсондоо химийн хорт бодисуудыг нь ялгасан түлш байдаг. Тэр түлшийг бид хэрэглээнд нэвтрүүлж эхлээд байна. Одоо 16 цэгт борлуулж байна. Анх намайг очоод танилцаж байхад хүмүүс нь "Бид шорлог хийж үзсэн. Ямар ч үнэр амтгүй гоё болж байна" гэж хэлж байсан. Тиймээс бид дөрвөн тонн нако түлшийг 75 өрхөд тарааж өгч байгаад, туршилтын журмаар хэрэглэж үзсэн. Ингэхдээ энгийн, сайжруулсан, нам даралттай уурын зуух, ханан пийшин гээд бүх төрлийн зууханд шатааж үзэхэд маш сайн үр дүн өгсөн. Түүхий нүүрс түлэхээр тортог үнэртдэг бол энэ нако түлшийг шатаж байхад нь зуухны тагийг авахад огт тортог үнэртэхгүй байсан. Утаа ч бараг гарахгүй байсан. Шаталтын чанар нь ч өндөр, 5000 орчим м2 дулаан ялгаруулахын зэрэгцээ маш бага хэрэглэгддэг юм билээ. Нам даралтын зууханд өдрийн 12:00 цагт найман хувин нако түлш хийгээд орой 17:00 цагийн үед очиход дулаанаа яг нэг хэвэндээ барьж байсан.

**-Улаанбаатарын гэр хорооллынхон бүгд түүхий нүүрс түлдэг. Шахмал түлшийг үр дүн багатай мөртлөө зардал өндөртэй гээд байдаг. Нако түлшний хувьд өртөг зардал нь хэр байдаг юм бол?**

-Нако түлш бэлдэхийн нүүрсийг өндөр температурт буюу 900-1100 хэмд боловсруулж, хорт бодисуудыг ялгачихдаг юм билээ. Нэг тонн нүүрс хийхэд 600 кг нако түлш гардаг гэсэн. Түүнээс биш бүр базаад, шахаад шахмал түлш шиг болгодог эд биш юм билээ. Үндсэндээ нүүрс нүүрсээрээ байгаа гэсэн үг. Манайд нако түлш нийлүүлэхээс өмнө нэг шуудай түүхий нүүрсний үнэ 6-8 мянган төгрөгийн хооронд хэлбэлзэж байсан. Тэгвэл бид 40 кг-ийн шуудайтай нүүрсийг 4500 төгрөгөөр борлуулж байгаа. 20 кг-ийнхыг 2300, 25 кг-ийг нь 2800 төгрөгөөр зарж байна. Яагаад ингэж үнийг багаар шийдэв гэвэл өнөөдөр Монгол Улсын эдийн засаг хямарчихсан, хүмүүс орлого, мөнгөгүй байна. Тиймээс бид үнийг хямдаар тогтоож, нөхөн олговрыг байгаль орчныхоо зардлаас өгөхөөр тооцоод байгаа. Хүн болгон л халаасаа уудалж, түлш авна. Ингэхдээ түүхий нүүрс авч түлээд утаа, угаар үйлдвэрлээд байгаа нь эдийн засагт ч, эрүүл мэндэд ч сөргөөр нөлөөлж байгаа учраас бид ердийн түүхий нүүрсний үнийн түвшинд нако түлшний үнийг барих хэрэгтэй. Нэг ёсондоо ингэж хүмүүстээ хэрэглээгээ бий болгож эхлэх хэрэгтэй. Нако түлш сайн гэдгийг л иргэдийнхээ толгойд суулгах гээд байгаа юм. Хэрэглээ нэмэгдэх тусам жил бүр үр дүнгээ өгөөд явна гэж бодож байна. Энэ түлш ирснээр түүхий нүүрсний үнэ унаж байгаа. Үнэндээ манай Эрдэнэт чинь өөрөө газар нутаг багатай учраас мод олддоггүй, Булган аймгаас авдаг. Булган аймгийнхан болохоор нөхөрлөлүүдээрээ бэлдүүлнэ гэдэг. Нөхөрлөлүүд нь бэлтгэхээрээ хангалтгүй, өндөр үнэтэй бэлтгэдэг. Тэгээд ч ер нь байгаль руугаа, мод руугаа хөрөө, сүх бариад ороод байх нь хэр зохистой ч юм. Монгол Улсын ойн баялгийн сан хэд билээ. Тийм учраас бид арай өөр түвшинд түлшин дээрээ ажиллая гэдэг бодолтой байгаа юм.

**-Утааны асуудлыг шийдэх өөр нэг арга нь гэр хорооллыг орон сууцжуулах явдал. Сая Эрдэнэтэд түрээсийн орон сууц хөтөлбөр амжилттай хэрэгжиж, нэлээд олон айл орон сууцанд орсон байсан. Бусдыг нь орон сууцжуулах боломж бий юу?**

-Ер нь боломж бүхнийг гаргана. Боломж хэзээд байдаг. Боломжийг гаргахгүй байх нь тухайн хүний л асуудал. Нэг ёсондоо сэтгэлийн асуудал л байхгүй юу даа. Би төрийн албаныхандаа "Төрийн албанд мэдлэг, туршлага, дадлага, чадвар гэхээсээ илүүтэйгээр сэтгэл дутдаг юм шүү нөхөд минь. Сэтгэлтэй байж төрийн ажлыг явуулах ёстой. Тийм учраас та бүхэн энэ асуудал дээр анхаарах хэрэгтэй" гэж байнга хэлдэг. Саяхан манайх түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Нийтдээ 450 гаруй хүний өргөдөл ирснийг сугалаагаар зохицуулж, хүмүүсийг байранд нь оруулсан. Цаашид энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх тал дээр анхаарч ажиллана. Мөн гэр хорооллын утаатай холбоотой авч хэрэгжүүлж байгаа нэг ажил бол цэвэр усны шугам татах төсөл. Одоогоор цэвэр усны зургаан худгаас шугам татаад гудамжны үзүүрүүдэд очичхон айл өрхүүд рүү ороогүй байгаа. Тэгэхээр энэ төслийг хэрэгжүүлэхээр Азийн хөгжлийн банкинд саналаа тавьчихсан байгаа. Мэдээж төслийн үр дүн хүний амьдралд хүрсэн байх ёстой. Тийм учраас тэр гудамжны үзүүрүүд дээр ирсэн шугамыг татаад өгчихье. Тэгээд айлууд холбох асуудлыг урт хугацааны бага хүүтэй зээлээр шийдэж өгөөч гэдэг санал тавьчихаад байгаа. Хэрвээ үүнийг хийж чадвал тодорхой хэмжээний үр дүн гарна. Цэвэр усаа оруулаад авчихвал халаалтаа өөр байдлаар шийдэх боломж бололцоо олгоно. Нөгөө талаар хөрсний бохирдлын асуудал үгүй болно. Утааны асуудал дээр ч гэсэн үр дүн гарна гэж бодож байна. Үүний зэрэгцээ бид бохирын болон дулааны асуудлыг шийдэх талаар БНСУ-тай ярьж байгаа зүйлүүд бий. Бид саяхан БНСУ-ын Шихэн хоттой найрамдалт харилцаа тогтоох, эрүүл мэнд, боловсрол, аж үйлдвэрийн салбарт хамтран ажиллах талаар санал солилцож, хотын удирдлагуудтай уулзаад ирсэн. Тэнд Аж үйлдвэр технологийн их сургууль гээд 7200 оюутантай том их сургууль байсан. Тэр сургуулийн тоноглолууд бүрэн хангагдсан. Төгссөн хүмүүс нь компанидаа ажилд ордог. 17 мянган аж ахуйн нэгжтэй хамтарч ажилладаг юм билээ. Миний түрүүний хэлсэн шинжлэх ухаан технологийн паркийн загвар яг тэнд байсан. Тэнд нэг бүтээгдэхүүн хийж байгаад, илүү сайжруулах гэсэн юм гээд захиалгаа өгдөг. Нөхдүүд ч сайжруулаад өгдөг. Тэгээд л мөнгө аваад сууж байх жишээтэй. Тэр нь дотоодын болон гадаадын зах зээлд гараад явж байдаг. Нөгөө шинжлэх ухаан технологийн парк чинь л энэ байхгүй юу. Тэгэхээр энэ чиглэлээр бид Шихэн хоттой хамтарч ажиллана. Хоёрдугаарт, гэр хороололд дахин төлөвлөлт хийх тал дээр Солонгосын талаас нэг санал тавьсан. Тодруулбал, нэг гудамжинд авсаархан байр барья. Бүх зардлаа өөрсдөө гаргая гэж байгаа юм. Тэгээд нэг гудамжны айлууд буюу 15-20 айлыг нэг байраар хангах төслийг ярилцаж байна. Одоо нэгдүгээр сард өөрсдөө ирж уулзаж, ярилцах юм. Хэрвээ энэ асуудлууд эхлээд явчих юм бол гэр хорооллын айл өрхүүдтэй холбоотой олон асуудал дээр дэвшил гарна. Мэдээж утаа, униар, хөрсний бохирдол гээд олон зүйл багасаад хүмүүсийн ажиллаж, амьдрах нөхцөл бололцоо сайжраад ирэхээр аяндаа хүмүүсийн сэтгэлгээ ч өөрчлөгдөнө. Ийм тодорхой зорилтууд тавиад ажиллаж байна. Боломж, бололцоо ч гарна гэж бодож байна. Одоо бид 1а хорооллыг ашиглалтад оруулах гэж байна. Энд нийт 1320 айлын орон сууц ашиглалтад орох ёстой. Хөрөнгө санхүүжилт нь дуусчихсан, инженер, техникийн хөрөнгийн асуудал зогсчихсон байсныг Ерөнхий сайд өнгөрсөн сард манайд айлчлахдаа ямар нэгэн байдлаар шийднэ гэж амласан. Ерөнхийдөө улсын төсөвт суулгалгүй, концессын гэрээний хэлбэрээр 6.2 тэрбум төгрөгийн асуудал шийдэгдэх байх.

**-Харьцангуй бусад аймгийг бодох юм бол Орхон аймаг сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ тийм ч дутмаг биш байх. Ерөнхийдөө байдал ямар байгаа вэ?**

-Энэ бол мөнхийн сэдэв болсон зүйл шүү дээ. Манайд одоохондоо гурван ээлжээр хичээллэж байгаа сургууль бараг байхгүй. Ганц нэг л газар байгаа байх. Цэцэрлэгийн асуудал бол нэлээд тулгамдаж байгаа. Ирэх оны төсөв дээр нэг цэцэрлэг барихаар төлөвлөсөн. Концессоор гурван цэцэрлэг барих асуудал БСШУСЯ дээр яригдаж байна. Бид цаашид баг болгоныг цэцэрлэгтэй болгох бодлого барьж ажиллана. Мэдээж бид Орон нутгийн хөгжлийн сангийнхаа хөрөнгөөр хийх ажил дээр 30 гаруй мянган хүнээс давхардсан байдлаар санал авсан. Тэр саналаа эрэмбэлж байгаад бид асуудалдаа хандаад явж байгаа юм. Ирэх оны төсөв дээр гэр хороолол руугаа инженерийн шугам сүлжээ татахаар 1.6 тэрбум төгрөг тавьсан байгаа.

**-Боловсрол, эрүүл мэндийн салбар аль ч газарт чухалд тооцогддог. Ер нь эрүүл мэндийн салбарын хувьд ямархуу байдалтай байна вэ?**

-Манай энд чинь Бүсийн оношилгоо, эмчилгээний төв байдаг. Үнэндээ том нэртэй л болохоос биш чадамж, техникийн хувьд муу байгаа. Угтаа бол бүсийн хэмжээнд үйлчлэх ёстой атлаа компьютер томографийн аппарат байхгүй, рентген аппарат нь эвдэрчихсэн, ашиглалтын хугацаа нь дуусчихсан, ийм л нөхцөл байдалтай байна. Энэ чинь босоо удирдлагатай байгууллага учраас яамнаасаа шийдүүлээд явах ёстой. Тэгэхдээ бид шат шатанд нь хөөцөлдөж байгаа. Ямар ч байсан энэ асуудлуудыг шийдэх учиртай. Бид дотоод асуудлуудтай нь танилцсан. Ингээд нярайн тасагт хэрэгтэй тоног төхөөрөмжүүдийг тавьж өгсөн. Сүүлийн үед төрөлт ихэсч байна. Гэтэл эмч нар төрөлт рүүгээ анхаарч байх хойгуур төрөлтийн өмнөх болон дараах хүмүүст асуудал үүсэх байдал мэр сэр гарч байгаа. Орон зайн хувьд ч гэдэг юм уу, цаг хугацааны хувьд шүү дээ. Тиймээс тэр байдлыг уялдаатай болгохын тулд төрөх тасгийг камержуулсан. Төрөхийн өмнөх болон төрсний дараах тасагт хэвтэж буй ээжүүд, төрөлт явагдаж буй өрөөг камержуулсан. Мөн тусламж хэрэгтэй эхчүүд товчлуур дараад л эмч, сувилагчийг дуудах боломжтой болгосон. Хоёрдугаарт, манайд жилд 20 орчим хүүхэд дутуу төрдөг гэсэн тоо байдаг. Дутуу төрсөн хүүхдийг амьдруулах гол зүйл нь уушги тэлэх тариа. Тэр уушги тэлэх тариаг бид авч өгсөн. Одоо ирэх оны төсөвт 35 сая төгрөг тусгасан. Энэ тариа байснаараа тухайн хүүхдийн амьдрах нөхцөл шууд 90 хувь хангагддаг гэж байгаа юм. Тэр бүгдэд бид 24 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Ирэх онд эмнэлгийн асуудал дээр засвар үйлчилгээ, эм тариатай холбоотой асуудлууд дээр нэлээд анхаарна. Ерөнхийдөө бидний анхаарах хамгийн гол зүйл бол эрүүл мэнд, боловсрол шүү дээ.

**-Камер ярьсных Эрдэнэт чинь ерөнхийдөө л гудамж, талбай гээд бүхий л газартаа камерын системийг бүрэн нэвтрүүлсэн газар байна билээ. Үүнтэй холбоотойгоор гэмт хэргийн гаралт ч багассан гэж байсан санагдана?**

-Өмнө нь камержуулалтын ажил явагдсан. Одоо ашиглалтад байгаа камерны 80 хувь нь л байна. Зарим нь эвдрэлтэй, зарим газруудад байршлуудаа буруу сонгосон, түүнээс болж үзэгдэх орчин нь хязгаарлагдсан гэх мэтчилэн эргэж харах зүйл байна. Тиймээс засвар үйлчилгээн дээр бид 20 гаруй сая төгрөг тавьсан. Засвар үйлчилгээ ерөнхийдөө хийгдчих байх. Манай төрийн үйлчилгээний нэгдсэн байр баригдаад дууcч байна. Тэнд бид камерын системийн хяналтын төвийг байгуулна. Ерөнхийдөө цагдаа, эрүүл мэндийн байгууллага, онцгой байдал, нийтийн тээвэр гээд нэг дороос бүгдийг нь хянах боломжтой болно гэсэн үг. Тэгэхээр түргэний тэрэг, нийтийн тээвэр хаана явж байна, яг үйлчилгээндээ явж байна уу, үгүй юу гэдгийг хянах боломжтой болно. Би Шихэн хотод очоод харж байсан. Тэнд Аюулгүй ажиллагааны төв гэж байгуулсан байсан. Ерөөсөө тийм байдлаар л тохижуулах гээд ярьж байгаа. Тус төвөөс хотынхоо 440 мянган хүнийг өдөрт 1-2 удаа хараад, бүх зүйлүүдээ хяначихдаг юм билээ. Тэгэхээр камержуулалттай холбоотой дутуу зүйл байгаа бол бүгдийг нь базаад нэгдсэн байдлаар шийдье гэдэг санаатай байна. Ингэж чадвал гэмт хэргийн гаралт, онцгой байдлын асуудал, нийтийн тээврийн хэл амны асуудал, түргэний асуудал гээд бүх асуудлыг нэг дор шийдэх боломжтой болно. Гэхдээ манайх нэг л газар байрлачихсан учраас хүртээмжийн хувьд их муу байдаг л даа. Түргэн тусламж гэхэд л ганцхан газар байдаг. Парк шинэчлэлт нь таарууxан. Тэгэхээр бид Эрүүл мэндийн яаманд энэ асуудлыг тавьсан. "Хэдэн орон тоо батлаад өгчихөөч, бид хөрөнгө оруулалтын асуудлыг нь шийдчихье" гээд. Тэгвэл гэр хорооллын төв байгуулна. Мөн өөр алслагдсан газруудад төв байгуулаад өгчихье. Тэр харьяалалдаа машин тэрэгтэйгээ үйлчлэх боломжтой байхаар ярьж байгаа. Энэ асуудал дээр Эрүүл мэндийн газрын дарга төсөл боловсруулж байгаа. Ер нь л аль болох төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулахын төлөө бид ажиллана. Тэгэхдээ 50, 50 хувийн оролцоотой байх хэрэгтэй. Төр нь үйлчилдэг, иргэд нь ч идэвхтэй байх хэрэгтэй. Түүнээс биш бүх зүйлийг л төрийн байгууллага хийх ёстой гэсэн өрөөсгөл ойлголттой байж болохгүй. Гэхдээ би албан хаагчиддаа ширээнийхээ ардаас босоод, гудамжинд очиж ажилла. Тэнд ард иргэд ямар байгааг очиж мэд гэдэг. Би өөрөө ч бас байн байн гадуур яваад асуудлуудтайгаа очоод танилцчихдаг.

**-Тун удахгүй хуучин он улирч, шинэ он айлчлан ирэх гэж байна. Энэ цаг мөчид Эрдэнэтчүүддээ хандаж та юу хэлэх вэ?**

-Юуны өмнө нийт Эрдэнэтчүүддээ гарч буй шинэ оны баярын мэндийг хүргэе. Мэдээж 2016 он та бүхний хувьд амжилт бүтээлээр дүүрэн, сайхан он жил болж өнгөрсөн гэдэгт би итгэл дүүрэн байна. Эрдэнэт хотын хувьд ч, Орхон аймгийн хувьд ч амжилт бүтээл арвин байсан. 40 жилийн түүхийг бүтээсэн, бүтээн байгуулалтад оролцож, хувь нэмрээ оруулж явсан, Зууны манлай бүтээн байгуулалт "Эрдэнэт" үйлдвэрийг байгуулсан эрхэм хүмүүсийн гавьяаг үнэлж, Эрдэнэт хотыг маань Сүхбаатарын одонгоор шагнасан. Өнгөрч буй 2016 онд УИХ болон аймаг, нийслэлийн сонгууль болж МАН үнэмлэхүй ялалт байгуулж, үйл ажиллагаагаа төлөвшүүлээд ажиллаад явж байна. Энэ мэтчилэн аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн болгон өөрсдийнхөө зорилгыг биелүүлсэн сайхан жил болсон гэж бодож байна. Ирж буй 2017 онд ч хүн бүр санаснаа биелүүлж, зорилгодоо хүрэхийг чармайсан сайхан он болно гэж бодож байна. Ер нь хүн мөрөөдөх хэрэгтэй. Тэр мөрөөдлөө биелүүлсэн сайхан жил болох болтугай гэж хүсч байна. Эрдэнэтчүүдийн хувьд та бүхний хувьд 2017 он таных байх болтугай хэмээн ерөөе.

ОНЦЛОХ ХУУДАС



# 2016 ОНЫ ОНЦЛОХ

2016 он Монгол Улсын хувьд тун онцлогтой жил байлаа. Энэ оны эхнээс бид сонгуулиар амьсгалж эхэлсэн. Мөн НӨАТ-ын сугалаанаас дор бүрнээ л мөнгө хожих гэж хүлээдэг болов. Мөн энэ жил Олимпийн наадам болж, Монголын тамирчид хоёр медаль авчирсан. Нөгөө талдаа эдийн засаг хүндэрч, ам.долларын ханш "тэнгэр"-т туллаа. Засгийн газар валютын ханшийн өсөлтийг сааруулах, эдийн засгийг сэргээх гэж хэрэндээ л юм болж байна. Гэвч одоохондоо гэрэл гэгээтэй мэдээ сонсогдохгүй л байгаа. Нэг иймэрхүү л онцлогтой жил болж өндөрлөлөө, ерөнхийд нь тоймлоход. Харин 2016 онд чухам ямар онцлох үйл явдал болсныг "Монголын мэдээ" сонин өөрсдийн өнцгөөс онцоллоо.



## Далд эдийн засгийг ухсан НӨАТ

Засгийн газраас иргэдийг урамшуулах, иргэдийн хэрэглээгээ хянах соёлыг төлөвшүүлэх, худалдаа үйлчилгээний төлбөрт багтсан НӨАТ-аас тодорхой хувийг буцаан авах, төлбөрийн баримтаараа бэлэн мөнгөний хонжвор бүхий сугалаанд оролцох боломжийг олгохоор НӨАТ-ын урамшууллын системийг энэ оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс бий болгосон. Өнөөдрийг хүртэл НӨАТ-ын сугалаанаас маш олон хүн мөнгө хожсон. 100 саяыг гэхэд л хэд хэдэн хүн хожчихоод байгаа. 20 саяыг бол маш олон хүн авсан. Тэр хэрээрээ иргэдийн амьдралд хэрэг болсон. Нөгөө талдаа татвараа үнэн зөвөөр нь мэдүүлж, төлдөггүй аж ахуйн нэгжүүдийн орлогыг баталгаажуулж, далд эдийн засгийг ухсан. Бүх аж ахуйн нэгжид хүрээгүй байх. Гэхдээ л томоохон аж ахуйн нэгжүүдийн татвараас бултдаг, орлогоо нуун дарагдуулдаг байдлыг халсан гэхэд болно. Түүний ачаар улсын төсвийн орлого ч тодорхой хэмжээнд нэмэгдсэн юм. Энэ системийг цаашид ч үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хүрээг нь илүү томсгож чадвал татвараас бултах байдлыг үгүй хийж болохоор байна. 2016 онд төсвийн орлогыг цөөнгүй хувиар нэмж чадсан НӨАТ-ыг онцлохгүй байхын аргагүй билээ.

## АН-ын цэвэр ялагдал



2016 оны хамгийн онцлох үйл явдлын нэг нь парламентын ээлжит сонгууль байлаа. Өмнөх парламентынхан сонгуулийн хуулиа дахин өөрчилж, мажоратор системээр явуулахаар болсон. АН-ынхан ялалтдаа бүрэн итгэлтэй байлаа. Ялдаггүй юм гэхэд хамтарсан Засгийн газар байгуулах хэмжээнд санал авна гэж төлөвлөж байв. Гэвч нөхцөл байдал санаанд оромгүй байдлаар өөрчлөгдөж, зургадугаар сарын 29-ний орой тэд далаараа цэвэр савуулсан. Ямар ч маргаан, өчиггүйгээр ялагдах нь тэр. Харин ялагдах юм уу эсвэл хамтарч засаг байгуулах хэмжээнд суудал хуваах болов уу гэж санаж байсан МАН-ынхан өөрсдөө ч гайхахаар хэмжээнд ялалт байгуулав. Бүр АН-ын томчуудад хаяж өгсөн "өгөөш"-үүд нь хүртэл УИХ-ын гишүүнээр сонгогдсон. Ард хэний ч санаанд оромгүй санал өгч, АН-ын дотоод эв нэгдэлгүй байдлын эсрэг "дунд хуруу" гаргасан юм. Ингээд л МАН УИХ-д 65 суудал авч, АН дөнгөж бүлэг байгуулах хэмжээний л гишүүнтэй үлдэв. Парламентанд сул гишүүн байснаас арай дээр гэсэн үг. Гэхдээ АН бүлгийнхний санал, шүүмжлэл, яриа хөөрөө МАН-д ёстой түй ч хамаа байхгүй. Тэд ямар ч шийдвэрийг олонхийн саналаар хүч түрэн батлах боломжтой болчихоод байна. Тэд дөрвөн жилийн хугацаанд улс орныг хааш нь залахыг харах л үлдээд байгаа юм. 2017 онд, цаашлаад 2018 он ч гэсэн биднийг маш томоор шалгах учиртай. Харин АН энэ том ялагдлынхаа дараа намаа шинэчлэх их ажлын эхлэлийг тавиад явж байгаа. Хамгийн гол нь ялагдлын нэг том шалтгаан болсон дотоод хэрүүл, тэмцлийг эцэс болгох, фракциудынхаа толхилцооныг дуусгах талаар ярьж эхэлсэн. Тэд үнэхээр шинэчлэгдэж чадвал 2020 онд хүчтэй болоод эргэж ирэх боломжтой.

## АСЕМ-ын олз

Сонгуулийн дараахан бид улсын баяр наадмаа хийж дуусгаад л долдугаар сарын 15-ны өдөр дэлхийн олон орны өндөр дээд албан тушаалтнуудыг улсынхаа нийслэл Улаанбаатар хотод хүлээж авсан. Учир нь Ази, Европын дээд хэмжээний 11 дэх уулзалт тэр өдөр эхэлсэн юм. Дээд хэмжээний уулзалтад АСЕМ-ын гишүүн 51 орон, үүнээс Европын 30, Азийн 21 орон, хоёр олон улсын байгууллагаас өндөр түвшний төлөөлөгчид оролцсон. Тэр дундаа төрийн тэргүүний түвшинд 10, Засгийн газрын тэргүүний түвшинд 23, Гадаад хэргийн сайдын түвшинд 16 орон оролцсон нь манайд болсон АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтад хэр зэрэг өндөр ач холбогдол өгснийг харуулсан хэрэг байлаа. Хамгийн гол нь манай улс энэ өндөр дээд хэмжээний уулзалтаас чамгүй




олзтой үлдсэн. Тухайлбал, Монгол Улсын хугацаа хэтэрсэн 38 тэрбум төгрөгийн өрийг тэглэсэн. Гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцжуулахад өмнөд хөрш 350 сая юанийн буцалтгүй тусламж үзүүлэхээ мэдэгдсэн. Монгол Улсад Итали улсын Элчин сайдын яам үүд хаалгаа нээж, үйл ажиллагаагаа эхлүүлсэн. АСЕМ-ын Дээд түвшний 11 дүгээр уулзалтад оролцохоор хүрэлцэн ирсэн Итали Улсын Гадаад хэргийн сайд Паоло Жэнтилони ЭСЯ-аа нээх үйл ажиллагааг удирдсан. Вьетнам улсын Ерөнхий сайд Нгуен Суан Фук Ерөнхий сайд Ж.Эрдэнэбаттай уулзах үеэрээ "Богд хааны ордон музей", "Чойжин ламын сүм"-ийг засварлахад туслах боломжтойгоо илэрхийлсэн бол Монголоос хөлдөөж боловсруулсан мах импортлох хүсэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгчид бараалхахдаа хэлсэн. Гэх мэтээр АСЕМ-аас манай улс олзтой үлдсэнээрээ хамгийн онцлох үйл явдал болсон юм.

## Мөнгө, хүрэл медальтай Олимп

2016 онд дэлхийн хэмжээнд болсон хамгийн гол онцлох үйл явдал бол Бразилын Рио хотноо болсон Олимпийн наадам байлаа. Энэ удаагийн Олимпийн наадамд манай улс урд өмнө нь байгаагүй өргөн бүрэлдэхүүнтэй оролцсон. Тэр дундаа жүдо, чөлөөтийнхөн бараг л бүтэн багаараа оролцсон. Тиймээс чөлөөтийнхнөөс 1-2 медаль хүлээж байлаа. Харин жүдочдоос түүнээс ч өндөр амжилтыг монголчууд хүлээсэн. Ерөөс Олимпийн өмнө манайхаас Д.Сумъяа болон С.Батцэцэг нарыг алтан медаль авна гэж олон спортын мэргэжилтнүүд, судалгааны байгууллагууд тооцож байсан. Гэвч чөлөөтийнхөн тэр чигээрээ нурсан. Ганц найдвар гэгдэж байсан С.Батцэцэг бэртлийн улмаас хүссэн дээ хүрсэнгүй. Харин Д.Сумъяа хэний ч итгэлийг алдаагүй. Тэр аварга болсон. Гэхдээ Бразилын бөхтэй финалд таарсан нь түүнийг мөнгөн медаль авах ёстой болгочихсон. Үндсэндээ бол Д.Сумъяа олимпийн аварга болсон. Шүүлт жаахан тиймэрхүү байсан л болохоос. Мөн энэ наадмаас боксын Д.Отгондалай хүрэл медаль авсан. Бас л булхайтай шүүлт биш байсан бол финалдах байв. Ерөөсөө Рио-2016 Олимпийн наадмын нэг том сэдэв булхайтай шүүлт байсан юм. Тэр дундаа бокс, чөлөөт, сонгомол бөхөд шүүлт олон булхай дагуулж, дэлхий нийтийг бухимдуулсан юм. Манайхаас хамгийн өндөр амжилт үзүүлсэн гурван тамирчин булхайтай шүүлтийн хохирогч болсон. Чөлөөтийн Г.Мандахнаран хүрэл медалийн төлөөх барилдаанд өрсөлдөгчөө ялсан. Гэвч шүүгчид илт



луйвардсанаар манай бөх хүрэл медалиа зүүж байгаад "хулгайд" алдсан юм. Тэгээгүй бол Монгол Улс хоёр хүрэл медальтай байх байлаа. Мөн шүүлтийн булхайг эсэргүүцсэн дасгалжуулагчид шавийнхаа, Монгол Улсын төлөө зүтгэснийхээ төлөө шийтгэл хүлээж, эрхээ хасуулаад л өнгөрсөн. Монгол Чөлөөт бөхийн холбоо хоёр дасгалжуулагчаараа "туг тахиад" дууслаа. Яах вэ, бүхэл бүтэн чөлөөтийн тамирчдын ирээдүйг аврах гарц үүнээс өөр байгаагүй байх. Гэхдээ л монголчууд ямар ч байсан чамлахааргүй амжилт гаргасан.

## Эдийн засаг "элгээрээ мөлхөв"

2016 онд гадаад валютын ханш түүхэнд байгаагүй өндөрт гарч, төгрөг цаас болох дээрээ туллаа. Тэр дундаа өнгөрсөн арваннэгдүгээр сарын эхээр валютын зах дээр ам.долларын ханш 3000 төгрөгт хэсэг зуур хүрээд буцаж буурсан. Одоо 2500 төгрөг хавьд тогтоод байна. Ам.доллар өсөхийн хажуугаар бусад валютын үнэ ч хөөрөгдсөн. Хятадын юань гэхэд саяхан л 150 төгрөг байсан бол ердөө ганц жилийн дотор л 350 төгрөгт хүрчихлээ. Гадаад валютын ханш ингэтлээ өсч байгаа нь маш олон талтай. Тэр дундаа Монгол Улсын валютын нөөц багасч, гадаадын шууд хөрөнгө оруулалт буурч, төлбөрийн тэнцэл алдагдалтай гарч байгаа нь нөлөөлж буй. Монгол Улсын Засгийн газраас ам.долларын ханшийн өсөлтийн эсрэг юу ч хийгээгүй. Зүгээр л Монголбанк руу чихсэн болоод өнгөрсөн. Төв банк шинэ удирдлагатай болсноор бодлогын хүүгээ огцом нэмж, 15 хувь болгосон. Ингэснээр зах зээл дээр байсан бэлэн мөнгийг татаж, ам.долларын ханшийг бага ч болов тогтоож барьсан. Мөн долоо хоног болгон интервенц хийсээр байсан юм. Харин арваннэгдүгээр сард хоёр удаа интервенц хийлгүй орхиход л ам.долларын ханш тэнгэрт тулах шахсан юм. Тухайн үед албаны хүмүүс зүгээр л хөөсрөл, улирлын чанартай өсөлт гэж мэдэгдээд л өнгөрсөн. Мөн эдийн засаг элгээрээ мөлхөж, хүнээр зүйрлэвэл "сэхээнд" орчихоод байна. Эрх баригчид эдийн засгаа сэргээх талаар ярьж байгаа ч энэ онд лав өөдөлсөн юм алга. Томоохон төслүүдээ хөдөлгөж, эдийн засгаа аварна гэж яриад байгаа ч одоохондоо шийдэгдсэн юм алга. Гаднаас зээл авч, ирэх оны эхнээс төлөгдөх өрөө дараад, улс орноо өөд нь татна гэж байгаа яг шийдэгдсэн юм байхгүй. Юу ч тодорхой болоогүй байна. ОУВС-гийн зээл ч шийдэгдээгүй хэвээрээ. Харин манай эрх баригчид Засгийн газраа байгуулж, ажлаа эхэлснээс хойш нүдэнд үзэгдэж, гарт баригдахаар дорвитой ажил хийж, шийдвэр гаргасангүй. Харин дарга нар гадаадад бөөн бөөнөөрөө айлчилж, урлагийн тоглолт хийж, мөнгийг 100 саяар нь цацахаас өөр ажил хийгээгүй л байна.





# 10 ҮЙЛ ЯВДАЛ

## Хэрүүлийн алим болсон "Эрдэнэт"

Сонгуулийн өмнөхөн тухайн үеийн Ерөнхий сайд Ч.Сайханбилэг "саалийн үнээ" гэгдэх "Эрдэнэт" үйлдвэрийг 100 хувь Монголын мэдэлд шилжсэнийг зарласан билээ. Тэр үеэс өнөөдрийг хүртэл хагас жилийн хугацаанд "Эрдэнэт" үйлдвэрийн 49 хувийг монголчууд худалдаж авсан асуудал "хэрүүлийн алим" болж хувирчихаад байна. Энэ асуудлыг УИХ-ын дэд дарга Ц.Нямдорж нэг хэсэгтээ л сэдэв болгож, хамгийн том луйвар хэмээн мэдэгдэж, ярьсан. Харин хувьчилж авсан талаас бүх зүйлийг хууль дүрмийн дагуу хийсэн гээд байгаа юм. Хамгийн гол нь Оросын талаас "Эрдэнэт"-ийн 49 хувийг Монгол Улсын Засгийн газарт санал болгосон ч авахыг зөвшөөрөөгүй гээд байгаа. Энэ нь хувь хүмүүст найр тавьсан хэрэг байсан ч гэж үзэж буй. Өнөөдрийг хүртэл "Эрдэнэт"-ийн асуудал хэрүүл хийх сэдэв болчихоод байна. Байсгээд л "Эрдэнэт"-ийг хэн нэгэн нь сөхөж ярьж, чуулганаар хэлэлцэх ёстой гэсэн асуудал ярьж байгаа. Ямар ч байсан "Эрдэнэт" 100 хувь Монгол Улсын мэдэлд шилжсэн нь 2016 онд болсон хамгийн том, онцлох үйл явдлын нэг байлаа. Харин цаашид төр засгийнхан энэ асуудлыг хааш нь болгох вэ гэдэг л асуудал үлдээд байна. Зарим улстөрчид ард түмэнд таалагдах сэдэв болгоод, хэт улстөржүүлээд явчихгүй л бол "Эрдэнэт" 100 хувь Монголын талд шилжиж байгаа нь муу зүйл л лав биш. Хамгийн гол нь төрөөс юу ч хамаагүй "Эрдэнэт" рүү шахдаг байдал энэ жилээр эцэс болж байгаа болов уу. Хувьчилж авсан нөхдүүд нь хүртэл "Эрдэнэт" рүү хамгийн их шахаа хийж байсан улстөрчид одоо энэ асуудлыг сүржигнүүлж байна хэмээн мэдэгдэж байсан удаатай. Тэд "Эрдэнэт" рүү юу юу шахаж байсныг жишээгээр дурьдаж, улстөрчдийн өөдөөс хувиа тавихгүй үзсээр байгаа. Ирэх онд ч гэсэн энэ асуудал үргэлжлэх байх.



## Баривчилгаа, шалгалт, нэгжлэг

Сонгууль болсон жилд нэг зүйл баталгаатай болдог нь хууль хяналтынхан улстөрчдийг шалгадаг, нэгждэг, баривчилдаг байдал. Энэ жишиг ч өнөө жил дахиад давтагдлаа. Хамгийн их дуулиан, шуугиан тарьсан нь Х.Баттулга болоод Н.Алтанхуяг нарыг тойрсон шалгалт, нэгжлэг, баривчилгаа байлаа. Тэгэхдээ өөрсдийг нь бол баривчлаагүй. УИХ-ын гишүүн асан Х.Баттулгын эзэмшлийн компаниудыг шалгаж эхэлсэн. Улмаар түүний туслах Г.Түвшинжаргалыг барьж хорьсон. Ердөө л Тавантолгойн асуудлаар тодорхой мэдээллийг өгсний төлөө түүний эргэн тойрон дахь туслах болоод зарим компанийн удирдлага гээд эмэгтэй голдуу хүмүүсийг баривчилж хорьсон юм. Түүнээс хойш энэ хүн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл өгөхөө больсон. Мөн Ерөнхий сайд асан Н.Алтанхуягийг Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихээ мэдэгдсэний дараагаас л эргэн тойрны хүмүүсийг баривчилсан. Түүний дүү болоод дүүгийнх нь охин гээд эмэгтэй голдуу хүмүүсийг барьж хорьж, бөөн сүр дуулиан болгоод амжсан юм. Энэ бүх баривчилгаа, нэгжлэг, шалгалтыг нэг хүнтэй холбож тайлбарласан. Тухайлбал, Ерөнхий сайд асан Н.Алтанхуяг "Хувь улстөрчийнхөө зүгээс ирэх оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвших хүсэлтэй байгаагаа мэдэгдснээс хойш олон үйл явдал өрнөж байна. Нөгөөтэйгүүр Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж нарын нөхдүүд амь тавьж байх шиг. Бид хоёр хоёулаа ардчилалын төлөө зүтгэсэн. Гэхдээ би Ц.Элбэгдоржийн үгэнд орохгүй бол шоронд явдаг



тийм ардчиллын төлөө яваагүй. Түүний үгэнд ормооргүй байна. Ойр дотны хүмүүсийг маань оролдож байхаар аль эрт намайг дуудаад байцаалт авчихгүй. Одоо тэднийг маань гаргаж, намайг тэр шорондоо хий. Би шоронд орсон ч эх орныхоо төлөө, энэ бүхний эсрэг тэмцсээр байх болно" хэмээн мэдэгдэж, байдлыг улам хурцатгасан. Энэ мэт баривчилгаа, улстөрчдийг тойрсон дуулиан, хэлсэн үг, ярьсан яриа нь 2016 оны онцлох үйл явдлуудын нэг байлаа.

## АН даргаа бүх гишүүдийнхээ саналаар сонгоно

УИХ-ын сонгуульд цөм ялагдсан АН шинэчлэлээ эхлүүлээд байгаа. Тэр дундаа намын даргаа бүх гишүүдийнхээ саналаар сонгохоор сонгууль зохион байгуулахаар болсон. АН-ын даргад Д.Эрдэнэбат, Н.Алтанхуяг, Ж.Батзандан, Л.Гантөмөр, С.Эрдэнэ гэсэн таван хүн өрсөлдөхөөр болж, сурталчилгаагаа хийж байгаа. Нэгдүгээр сарын 29-нд намын даргын сонгууль болж, эдгээр таван эрхмээс нэг нь сонгогдох учиртай. Тэр болтол хамтдаа 21 аймгаар явж, өөр өөрсдийн бодлого, мөрийн хөтөлбөрөө танилцуулах юм. Гэхдээ тус тусдаа сурталчилгаа хийхгүй байгаа. Энэ нь фракцийн хагарлаас болж сөнөх дээрээ тулчихаад байгаа АН-ыг аврах гарц гэж тэд үзэж байгаа юм. Шинээр сонгогдсон дарга намаа шинэчлэх тал дээр дорвитой ажил хийж, хэрэгжүүлэх биз ээ. Учир нь намын даргад нэр дэвшигчид бүгдээрээ шинэчлэл, шударга ёсыг хүсч байгаагаа нэр дэвшигчийн үнэмлэхээ гардаж



авахдаа хэлсэн. С.Эрдэнэ "Бид өнөөдөр АН-ын шинэтгэлийн их аянд хамтдаа гарч байна. Энэ сунгаа бидний шинэчлэлийн төлөөх хувь нэмэр, хамтын зүтгэл гэж харж байна" хэмээн хэлсэн. Харин Д.Эрдэнэбат "Миний хувьд унаж байгаа ардчиллын үнэлэмжийг дээшлүүлэх, баталгааг хангах, АН-ын шинэтгэлийг цоо шинэ суурин дээр авч явах шинэчлэлийг шаардаж байгаа учраас намын даргын сунгаанд оролцож байна. 2016 оны сонгуулийн дараах уналт, сургамж энэ намыг цаашид яаж авч явах вэ гэсэн дохиог өгч байна. Орон нутгийн сонгууль ч гэсэн АН үндэсний хэмжээний нам гэдгийг харуулсан" хэмээсэн. Тэгвэл Н.Алтанхуяг "АН-ын олон гишүүдийн са¬налыг хүлээн авч Монгол¬доо иргэн бүр сайхан амьдрахын төлөө хамтдаа ажиллая гэж намын даргад өрсөлдөж байна. Нэгнээсээ давах гэсэн аминчхан үзлээ мартаж, их зорилгоо биелүүлэхийн тулд давахгүй саад бэрхшээл байхгүй. Эвийн хүчээр хамтдаа бүгдийг бүтээцгээе" хэмээн хэлсэн юм. Энэ мэтээр бүгд л шинэчлэлийг хүсч байгаагаа илэрхийлсэн. Ямар ч байсан АН шинэ жишгийг нэвтрүүлж, анхдагч болж чадлаа.

## Хятадын өмнө бөхийлгөсөн Далай ламын айлчлал

Үе үехэн манай улсад хүрэлцэн ирж, сургааль номлолоо айлддаг Далай лам энэ оны төгсгөлд Монголд ирээд буцсан. Энэ айлчлал эхнээсээ л асуудал дагуулсан. Зарим нэг лам хэвлэлийн хурал зарлаж, эсэргүүцэж байгаагаа дуулгасан. Мөн Хятадын талаас ч анхааруулга өгч байсан юм.



Гэвч Далай лам ирдгээрээ ирж, сүсэгтэн олонтой уулзаж, манай улсад хэд хоноод буцсан. Харин анхааруулга өгч байсан Хятадын талаас манайхыг илт буруушааж, албан ёсны айлчлал, уулзалтаа бүгдийг нь цуцалсан. Тус улсаас зээлэх гэж байсан мөнгө болоод томоохон төслүүдэд хийх хөрөнгө оруулалтын асуудал ч босч ирэх нь тэр. Тиймээс ГХ-ны сайд Ц.Мөнх-Оргил Монгол Улсын Загсийн газрыг төлөөлж Хятадын талаас уучлал гуйж, наад зах нь ойрын дөрвөн жил Далай ламыг Монголд дахиж айлчлахыг хүлээн зөвшөөрөхгүй гэдгийг ч хэлээд байгаа. Уг нь Монгол Улс бол тусгаар тогтносон орон. Гэвч эдийн засгийн нөхцөл байдлын улмаас бид тусгаал улс гэдгээ түр хойш нь тавьж, Хятадын Засгийн газраас уучлал гуйлаа. Ерөөс дэлхийн бусад улс орнууд ч Хятадтай хамтын ажиллагаагаа цэглэхгүй, худалдаа эргэлтээ бууруулахгүй, хамгийн том худалдан авагчаа алдахгүйн тулд Далай ламаас татгалзсан жишээ маш их байна. Манайх шиг жижиг орны хувьд хэдийгээр Хятадаас хараат бус, бие даасан, тусгаар улс ч гэсэн эдийн засгийн нөхцөл байдал яах аргагүй толгой гудайхаас өөр арга байхгүй юм. Яахав, нэг удаадаа толгой бөхийчихөөд, дараа нь тэргүүнээ өргөхөд болохгүй юм байхгүй. Одоохондоо энэ Засгийн газрын ганц авралын "од" нь Хятад бол толгой гудайж, уучлал гуйхгүй гээд ч яах юм билээ. Нөхцөл байдал энэ хэвээрээ удаан байхгүй л болов уу. Гудайх нэг үе байхад сэхэх ч үе бий. Тэр үедээ бид хэнийг ч тоолгүй хэн нэгнийг улсдаа авчирч болох байлгүй дээ.



## Зоригийн хэрэг илэрч, хэрэгтнүүд ял сонслоо

Тэртээ 18 жилийн өмнө Монгол Улсын төр нийгмийн зүтгэлтэн, Ардчиллын алтан хараацай С.Зоригийн амь насыг хэрцгийгээр бүрэлгэсэн хэрэг гарсан билээ. Энэ хэргийг цагдаагийн байгууллагынхан 18 жил мөрдөн шалгасны эцэст илрүүлж, хэрэгтнүүдийг баривчилсан. Ц.Амгаланбаатар, Т.Чимгээ, Б.Содномдаржаа гэсэн гурван хүнийг барьсан, хорьсон, ялласан. Цагдаа нар удаан мөрдсөний эцэст яллах дүгнэлт үйлдэж прокурорт шилжүүлсэн. Прокурор хэрэг мөрдөлтийг хянаж үзээд яллах дүгнэлт үйлдсэн. Шүүх ялаа оноолоо. Тэднийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91.2.1, 91.2.4, 91.2.6, 91.2.10, 91.2.11, 91.2.12, 91.2.13, 91.2.16 гэсэн зүйл заалтаар яллаж, Ц.Амгаланбаатар, Б.Содномдаржаа нарт 25 жил, Т.Чимгээд 24 жилийн ял оноолоо. Ингэснээр 18 жил үргэлжилсэн С.Зоригийн хэрэг илэрч, ард нь гарлаа. Мэдээж хэргийг илрүүлж, хэрэгтнүүдийг ялласантай зэрэгцээд нийгэмд янз бүрийн хардлага гарч байгаа. Эдгээр хэрэгтнүүд 1998 онд 16 болоод 20 гаруйхан настай байсан. Хөдөө мал маллдаг байсан хүмүүс. Хот ч орж үзээгүй байсан. Тийм болохоор хэрэг үйлдэх боломжгүй. Хүн гүтгэлээ гэх яриа ч гарч байгаа. Гэхдээ цагдаагийн байгууллага зүгээр сууж байгаад гурван хүн хэлмэгдүүлчихнэ гэж юу байх билээ. Ямар ч байсан С.Зоригийн хэргийг шийдвэрлэлээ. Мэдээж тэднийг захиалгаар бусдын амь насыг хөнөөсөн гэж ялласан. Цаашлаад захиалагчийг нь олохын төлөө цагдаагийн байгууллага ажиллах байх. 18 жил үргэлжилсэн хэргийг 2016 онд дуулиан шуугиантай шийдвэрлэлээ.

ОНЦЛОХ ХУУДАС



# Дэлхий дахинд өрнөсөн

2016 онд дуусч байна. Сири, Иракийн ихэнхи газар нутгийг хяналтдаа авсан хэт даврагч “Лалын улс” бүлэглэл бут цохигдож, Колумбид хагас зуун жил үргэлжилсэн иргэний дайн төгссөн бол Их Британи ЕХ-оос гарах болж, Нэгдсэн Европ задрахад хүрэв. Энэ мэтээр сайн муу үйл явдал зэрэгцэн өрнөсөн 2016 он улирч, Хүн төрөлхтөн сургамжаар дүүрэн, гайхамшигт нэгэн оныг үдлээ. Тиймээс “Монголын мэдээ” сонин энэ удаа дэлхий дахинаа өрнөсөн онцлох 10 үйл явдлыг нэрлэж байна.

## 1. АНУ-ын сонгуульд “битүү морь” гарч ирэв



Дэлхийн хүчирхэг нэгэн гүрэн болох АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль 2016 оны арваннэгдүгээр сарын 8-нд болж, хэний ч төсөөлөөгүй “битүү морь” гэж хэлж болохуйц улс төрд зүтгэсэн туршлагагүй нялх улстөрч Доналд Трамп илт давуугаар ялалт байгуулсан нь дэлхий дахиныг шоконд оруулсан юм. Ардчилсан нам, Бүгд найрамдах нам гэсэн хоёр том улс төрийн хүчнээс Ерөнхийлөгчид нэр дэвшигчийг тодруулах сонгаа ч бүтэн жилийн турш ширүүн өрсөлдөөнтэй үргэлжилсэн. Тодруулбал, Бүгд найрамдах намын сонгаанд нийтдээ 16 өрсөлдөгч нэрээ дэвшүүлэн өрсөлдсөнөөс Техас мужийн сенатч Тед Круз, үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп нарын хооронд гол өрсөлдөөн өрнөж, эцсийн мөчид Тед Круз нэрээ татсанаар бизнесмэн эр ганц ч өрсөлдөгчгүйгээр БНН-ын сонгаанаас АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд тунаж үлдсэн. Харин Ардчилсан намын сонгаанд найман улстөрч нэр дэвшсэнээс Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтон, сенатч Берни Сандерс нар тунаж, АНУ-ын сонгуульд нэр дэвшигчийг тодруулах намын их хурлаар улстөрч бүсгүй цагаан ордны төлөөх өрсөлдөөнд нэг алхам урагшилсан удаатай. Ийнхүү улс төрийн арвин туршлагатай эмэгтэй улстөрч, бизнесийн салбарт танигдсан магнаттай АНУ-ын Ерөнхийлөгч болохоор өрсөлдсөн. Тэдний сурталчилгааны арга барил, халз мэтгэлцээн, эцсийн дүн урьд хожид байгаагүй дуулиан шуугиантай байв. Нэр дэвшигчдийн байр суурь ч эсрэг тэсрэг байлаа. Доналд Трампын хувьд “Аугаа Америкийн дахин сэргээнэ” гэх уриан дор хууль бус цагаачдыг улс орноосоо хөөн гаргаж, терроризмоос сэргийлэх үүднээс лалын шашинтнуудыг АНУ-д нэвтрүүлэхгүй байх, ажлын байрыг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх нэрээр гаргаж буй асар их зардлыг танах, Номхон далай дамнасан хамтын ажиллагааны гэрээнээс улс орноо гаргах, Мексик АНУ-ын хил дээр хана босгоно гэх мэтчилэн эрс ширүүн мэдэгдлийг хийж байснаас гадна Ойрхи Дорнодын асуудалд ОХУ-тай хамтран хэт даврагч “Лалын улс” бүлэглэлийн эсрэг тэмцэнэ гэдгээ илэрхийлж байлаа. Харин Хиллари Клинтоны тухайд Барак Обамагийн бодлогыг үргэлжлүүлнэ гэдэг нь тодорхой байсан юм. Сонгуулийн өдөр дөхөх тусам нэр дэвшигчдийн хоорондын тэмцэл ширүүсч, хувийн асуудал ч олонд дэлгэгдэж байв. Доналд Трампын эмэгтэйчүүдийг зүй бус үгээр гутаан доромжилсон бичлэг, хохирогч эмэгтэйчүүдийн мэдэгдэл хэвлэлээр гарч, харин эсрэгээр Хиллари Клинтоны нөхөр Билл Клинтоны ч төрийн тэргүүн байх үеийн хормойн явдал ч олонд дэлгэгдэж байлаа. Гэхдээ сонгуулийн эцсийн дүн л санаанд оромгүй байсан юм. Жил гаруй хугацаанд үргэлжилсэн АНУ-ын дараагийн тэргүүн хэн байх вэ гэх асуултад улс төрийнхөн, одууд, эдийн засагчид гээд бүхий л нөлөө бүхий хүмүүс Хиллари Клинтоныг ялах магадлалтай хэмээж байсан ч, эцэст нь битүү морь гарч ирсэн нь Доналд Трамп байв. Трампаас даруй гурван сая хүний санал илүү авсан ч, төлөөлөгчдийн саналаар ялагдсан Хиллари Клинтон өөрийн ялагдалдаа ОХУ-ын тэргүүн В.Путин болон тус улсын хакерууд, мөн сонгуулийн явцад хувийн емэйлийн асуудлыг дэлгэсэн АНУ-ын Холбооны мөрдөх товчоог буруутгаж буй. Д.Трамп ирэх сарын 20-нд тангарагаа өргөх бөгөөд дэлхийн нэгэн хүчирхэг гүрнийг тэрбээр хааш нь чиглүүлэх нь олон улсын анхаарлын төвд үлдлээ.



## 2. Дотны найздаа хэт итгэсэн Пак Гын Хэгийн карьер дууслаа

1961 онд БНСУ-д төрийн эргэлт хийн эрх мэдлийг гартаа авч, амь үрэгдэх хүртлээ 18 жилийн турш тус улсын Ерөнхийлөгчөөр ажилласан Пак Жон Хэгийн охин буюу ардчилсан сонгуулиар сонгогдон анхны эмэгтэй Ерөнхийлөгч Пак Гын Хэ дотны найздаа хэт итгэснийхээ улмаас Ерөнхийлөгчийн албан тушаалаасаа хүчээр буусан нь энэ оны анхаарал татсан үйл явдлын нэг байлаа. Эхийгээ цаг бусаар алдаж, эцгийгээ амьд сэрүүн ахуйд тэргүүн хатагтайн үүргийг гүйцэтгэж явсан Пак эрх баригч Сэнүри намаас Ерөнхийлөгчид нэр дэвшин сонгогдсоноос хойш түүний рейтинг дотооддоо ч, олон улсад ч тасралтгүй өсч байв. Гэвч эцэг эхийг нь нас барснаас хойш Пактай дотно нөхөрлөж, Ерөнхийлөгчөөр сонгогдсон үеэс нь нөлөө бүхий болсон найз Чой Сун Шил гэгч эмэгтэй энэхүү харилцаагаа ашиглан БНСУ-ын томоохон корпорациудаас их хэмжээний хөрөнгийг өөрийн байгуулсан сандаа хандив нэрийдлээр авч, нууцын зэрэглэлтэй улс төрийн материалыг засдаг байсан нь илэрснээр томоохон дуулиан дэгдсэн юм. Дуулиан шуугианаар Пак Ерөнхийлөгч өөрийн гэр бүл болоод эрх баригч намын нэр хүндийг навс унагаад зогсохгүй албан тушаалаасаа огцрох дээрээ тулсан.

Түүний хувьд хэд хэдэн удаа ард түмэндээ хандан мэдэгдэл хийж, найзаасаа тусламж авч байснаа хүлээн уучлал хүссэн ч, прокурорууд Чой Сун Шилийн хэрэгт Пак Гын Хэ ч оролцсон гэж мэдэгдсний дараа сүрийг үзүүлсэн эсэргүүцлийн жагсаал цуглаан өрнөсөн билээ. Түүнчлэн, сөрөг хүчнээс өөрийн хүслээр албан тушаалаасаа буух шаардлагыг удаа дараа Ерөнхийлөгчид хүргүүлж, мөн БНСУ-ын парламент түүнд итгэл үзүүлэх эсэх асуудлаар санал хураалт явуулав. Ерөнхийлөгчийн хувьд парламентын шийдвэрийг дагана гэдгээ өмнө нь илэрхийлсэн бөгөөд энэ сарын 9-нд болсон санал хураалтаар түүнийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх шийдвэр гарсан юм. Харин Үндсэн хуулийн шүүх уг шийдвэрийг зургаан сарын хугацаанд хэлэлцэн Ерөнхийлөгчийг албан тушаалаас нь огцруулах эсэхийг шийдвэрлэх учиртай. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр гарах хүртэлх хугацаанд тус улсын Ерөнхий сайд Хван Кё Ан ерөнхийлөгчийн үүргийг гүйцэтгэх юм. Ямартай ч, 2014 оны 300 орчин хүний амь эрсэдсэн Севол хөлгийн ослын дараа ч суудлаасаа буугаагүй Ерөнхийлөгч нөхөрлөлийнхөө улмаас ийнхүү огцроход хүрэв. Тэрбээр бүрэн эрхийнхээ хугацааг дуусгасан бол 2018 онд албан тушаалаасаа буух байсан юм.



## 3. Р.Эрдоганы вант улс нуран унах “дөхөв”

Ерөнхий сайдаар 11 жилийн турш тасралтгүй ажиллаж, 2014 оноос хойш Ерөнхийлөгчийн үүргийг гүйцэтгэх болсон Туркийн “султан” Ресеп Тайип Эрдоганыг түлхэн унагах зорилготой цэргийн эргэлт хийх оролдлого өнгөрөгч долдугаар сард гарав. Долдугаар сарын 15-аас 16-нд шилжих шөнө туркийн армийн өндөр албан тушаалтнууд Ресеп Тайип Эрдоган амралтаа авсан завшааныг ашиглан цэргийн эргэлт хийхийг завдсан. Эрдоганы амарч байсан зочид буудлын өрөө рүү нисдэг тэрэгнээс буудаж, Ерөнхийлөгчийн ордон, парламентын ордныг Ф-16 сөнөөгч онгоцоор пуужингаар харваж, Станбул, Анкара дахь олон улсын нисэх онгоцны буудал, Боспорын хоолойг дамнасан стратегийн чухал гүүр, эрх баригч намын төвийг дайран эзэлсэн гээд төрийн эргэлт хийхэд хийх ёстой бүхий л алхмуудыг амжилттай хийсэн. Улмаар Туркийн армийн Жанжин штаб улс орны бүх эрх мэдлийг гартаа авсныг мэдэгдээд улс даяар онц байдал зарлав. Харин Р.Эрдоган видеоутсаар ярилцлага өгч Туркийн жирийн иргэдэд хандан төрийн эргэлт хийх гэсэн оролдлогыг дэмжихгүй байх, гудамж талбайд олноороо гарч эсэргүүцлээ илэрхийлэхийг уриалсан. Иргэд ч түүний уриалгыг дэмжин томоохон хотуудад эсэргүүцлийн жагсаалыг өрнүүлснээр цэргийн дэглэм хэдхэн цагийн дараа нуран унасан юм. Энэ үеэр 300 орчим энгийн иргэн амиа алдсан гэсэн мэдээлэл бий. Оролдлогыг дарсан даруйд армийн өндөр албан тушаалтан болон тусгай хүчний албан хаагч гээд нийт 3000 гаруй хүнийг баривчилж, мөн хэдэн арван мянган төрийн албан хаагчийг ажлаас нь халсан удаатай. Туркийн эрх баригчдын хувьд энэ оролдлогыг АНУ-д амьдарч буй шашны номлогч Ф.Гюллен, түүний байгуулсан ФЕТА нэртэй байгууллагын гишүүд зохион байгуулсан гэж буруутгасан. Улмаар АНУ-аас Гюлленыг өгөхийг шаардсан ч үр дүнд хүрээгүй.



## 4. Их британичууд ЕХ-г орхилоо

Энэ оны зургадугаар сарын 23-нд Их Британийг Европын Холбооноос /ЕХ/ гарах эсэхийг шийдэх бүх нийтийн санал асуулга боллоо. Санал асуулгад оролцогчдын 52 хувь нь ЕХ-ноос гарахыг дэмжсэн бол 48 хувь нь ЕХ-нд үлдэхийн төлөө саналаа өгөв. Ингэснээр Их Британи нь ЕХ-ноос гарахаар шийдсэн анхны улс болсон юм. Санал хураалтын дүнгийн зөрүү бага байсан ч Их Британийг Европын Холбоонд үлдэхийг дэмжиж байсан Ерөнхий сайд Дэвид Камэрон санал хураалтын дүнтэй холбогдуулан албан тушаалаасаа огцорсон. Харин түүний оронд Британийг Европын Холбооноос гаргахыг дэмжих байр суурь баримталж байсан Тереза Мэй Консерватив намын гишүүдийн саналаар Их Британийн дараагийн Ерөнхий сайдаар сонгогдон томилогдлоо. Ийнхүү М.Тэтчерээс хойш олон жил өнгөрсний дараа Их Британийн Ерөнхий сайдаар ахин эмэгтэй хүн ажиллахаар томилогдсон нь мөн л дэлхий дахинаа болсон дуулиант үйл явдлын нэг байсан юм. Их Британийн сонгогчид Их Британийг Европын Холбооноос гаргах тухайгаа ийнхүү илэрхийлсэн нь Их Британийн улстөрийн намуудыг төдийгүй Европын холбооны гишүүн улс орнуудыг цочролд оруулсан. ЕХ-ноос албан ёсоор гарах асуудлаарх хэлэлцээг хоёр жилийн дотор хийж дуусгах ёстой. Их Британийн Ерөнхий сайд Тереза Мэйгийн мэдэгдсэнээр, ЕХ-ноос гарах асуудлаарх хэлэлцээрийн эхний алхмаа ирэх оны гуравдугаар сард хийх юм.

## 5. Рио Де Жанейро хотноо XXXI дэх удаагийн зуны олимп болов



Хүн төрөлхтний эв нэгдлийн бэлгэ тэмдэг болсон зуны Олимпын XXXI наадам энэ оны наймдугаар сарын 5-21-нд Бразил улсад боллоо. Шумуулаар дамждаг “зика” вирус тархаж, эдийн засгийн хямрал улам даамжирч, төсвийн мөнгийг зориулалт бусаар ашигласан гэх үндэслэлээр Ерөнхийлөгч Дилма Руссеффыг албан тушаалаас нь түдгэлзүүлэхэд хүрээд байсан хэдий ч Өмнөд Америкийн 200 сая гаруй хүнтэй энэ улс Олимпын наадмыг амжилттай зохион байгуулсан юм. “Рио-2016” наадамд нийт 206 улс болон засаг захиргааны тусгай бүсийн 10 500 гаруй тамирчин оролцлоо. АНУ-ын баг тамирчид нийт 121 медаль хүртсэн амжилтаар албан ёсны бус багийн дүнгээр тэргүүлсэн бол БНХАУ 70 медальтайгаар хоёрдугаар байрт, Их Британи 67 медальтайгаар гуравдугаар байрт шалгарсан юм.

Орос, Герман, Франц, Япон, Австрали, Итали болон Өмнөд Солонгосын баг тамирчид медалийн тоогоор эхний 10-т багтсан бол Монгол Улсын тамирчид нэг мөнгө, нэг хүрэл медаль хүртсэн амжилтаар 67 дугаар байрт жагслаа. Төрөөс санхүүжүүлсэн сэргээшийн хөтөлбөрт тамирчид нь хамрагдсан гэсэн шалтгаанаар Оросын хөнгөн атлетикийн баг тамирчдын Олимпын наадамд оролцох эрхийг хассан билээ.

ОНЦЛОХ ХУУДАС



# ОНЦЛОХ 10 ҮЙЛ ЯВДАЛ



## 6. Загалмайтны онилсон халдлагууд

2014 оноос хойш Сири, Иракийн хойд хэсгийн ихэнх газар нутгийг хяналтдаа авсан хэт даврагч Лалын улс бүлэглэлийн эсрэг ширүүн дайн энэ онд өрнөж, тус бүлэглэлийн нөлөө суларсан. Гэвч, эсрэгээр Европыг чиглэсэн террорист халдлагууд энэ онд 30 гаруй удаа болжээ. Эдгээрээс хамгийн олон хүний амь эрсэдсэн халдлагуудыг нэрлэе. Үндсэндээ 30 гаруй удаагийн халдлагаас гурав нь ихээхэн хэмжээний хохирол дагуулжээ. Гуравдугаар сарын 22-нд Бельгийн нийслэл Брюссель хотын нисэх буудалд болон Малбек гэдэг метроны шугамд цуврал халдлага гарсны улмаас 28 хүн амь үрэгдэж, 250 гаруй хүн шархаджээ. Бельгийн эрх баригчид энэхүү халдлага үйлдсэн бүрүүтай этгээдүүдийг олохын тулд тусгай арга хэмжээ авахад хүрч, анх удаагаа онц байдал зарлаж байлаа. Террористуудын дараагийн бай Францын Ницце хот байв. Франц Улсын Үндэсний баяр болох Бастиль цайзыг эзлэн авсны баярын өдөр Газар дундын тэнгисийн эрэг дээр байдаг амралт жуулчлалын Ницце хотын гудамжинд баярын салют буудахыг харахаар цугларсан олон хүмүүс рүү ачааны машин хөлөглөсөн алан хядагч этгээд дайрсны улмаас 80 гаруй хүн амь үрэгдэж, 200 орчим хүн шархаджээ. Энэ аймшигт хэрэг долдугаар сарын 14-ний өдөр болсон юм. Тэгвэл саяхан гэхэд ХБНГУ-ын нийслэл Берлин хотын төвд байдаг Брайтшайдплац талбайд зул сарын зах дээр цугларсан олон хүмүүс рүү Тунисын гаралтай Анис Амри хэмээх алан хядагч мөн л ачааны машинаар дайрсны улмаас 12 хүн амь үрэгдэж, 48 хүн шархаджээ. Алан хядагч хэргийн газраас зугтсан байсан бөгөөд түүнийг энэ сарын 23-ны өдөр Италийн Сесто-Сан-Жованни хот руу зугтан гарсан байхад нь олж устгасан байдаг.




## 7. Туркид суух ОХУ-ын Элчин сайд буудуулж, амиа алдлаа

ОХУ-аас Туркид суух Элчин сайд Андрей Карлов Анкара хотын Орчин үеийн урлагийн төвд "Орос орон туркуудийн нүдээр" сэдэвт гэрэл зургийн үзэсгэлэнгийн нээлтэд оролцож байхдаа Туркийн цагдаагийн ажилтан Мэрт Алтынташ гэх 22 настай залууд араасаа буудуулан амь үрэгдсэн хэрэг дэлхий дахинаа өрнөсөн онцлох үйл явдлын нэг байв. ОХУ-ын Элчин сайд Андрей Карлов Туркийн нийслэлд болсон уран зургийн үзэсгэлэнд оролцож, үг хэлэх үед нь гэмт этгээд араас нь буудан амийг нь бүрэлгэжээ. Түүнийг микрофоны өмнө гарч, ердөө хэдхэн минут үг хэлж байхад нь костюм өмсч, зангиа зүүсэн этгээд найман удаа гал нээжээ. Мөн гэмт этгээд "Бид Алеппод үхэж байна. Харин чи энд үх", "Алеппог мартаж болохгүй, Сирийг битгий мартаарай" хэмээгээд "Хойшоо болцгоо, хойшоо болцгоо. Зөвхөн үхэл л намайг эндээс авах болно. Намайг эсэргүүцсэн хэнийг ч хөнөөх болно" гэх зэрэг үгсийг урсгаж байсныг гэрчүүд мэдээлж байв. Харин түүнийг ийн байхад Туркийн нэгэн цагдаа буудан хөнөөжээ. Сирийн арми Алеппо хотыг хэт даврагчдаас чөлөөлөх тэмцлийг эхлүүлж, ОХУ-ын цэргийнхэн агаараас бөмбөгдөж байсан юм. Энэ үеэр олон энгийн иргэний амь үрэгдэж байгааг барууны хэвлэлүүд онцолж байлаа. Ямартай ч, хэрэг гарсны дараа ОХУ ямар хариу үйлдэл үзүүлэх нь олон улсын анхаарлын төвд байсан бөгөөд тэдний хувьд хэргийг "Террорист халдлага" гэж үзэж буйгаа мэдэгдсэн байна. Талийгаачийн хувьд 2013 онд Туркид суух Элчин сайдаар томилогдож байжээ. Залуу Элчин сайдыг ямар шалтгаанаар хөнөөсөн нь тодорхойгүй. ОХУ-ын Засгийн газар хэргэт яаран дүгнэлт хийхгүй байхыг илүүд үзэж байгаа юм. Гэхдээ Туркийн тухайд шашны номлогч Ф.Гюлены хийсэн хэрэг хэмээн үзэж, санаатайгаар Турк-ОХУ-ын харилцааг хөндийрүүлэх зорилготой гэж үзэж буй бол зарим албаныхан Алеппод явуулж буй Оросын цэргийн ажиллагаат эсэргүүцэн Элчин сайдын амийг бүрэлгэсэн хэмээн үзэж байна.



## 8. Хуан Мануэль Сантос Нобелийн энх тайвны шагнал хүртэв

Улирч буй 2016 онд дэлхий дахинаа өрнөсөн онцлох сайхан үйл явдлын нэг нь Колумбид хагас зуун жилийн турш үргэлжилсэн иргэний дайнд цэг тавигдсан явдал байлаа. Тус улсын Ерөнхийлөгч Хуан Мануэль Сантос болон "ФАРК" босогчдын бүлэглэлийн ерөнхий командлагч Тимолеонт Хименес нар энэ оны есдүгээр сарын 26-нд Картегана хотод энхийн гэрээнд гарын үсэг зурснаар тус улсад 52 жилийн турш үргэлжилсэн иргэний дайн төгсгөл болсон юм. Сөргөлдөгч талууд Кубын нийслэл Гавана хотод дөрвөн жилийн турш хэлэлцээ хийсний эцэст уг гэрээнд гарын үсэг зурсан байна. 1960-аад оны үед газар өмчлөх эрхтэй холбоотойгоор бослого гарснаар Колумбийн Засгийн газар болон "ФАРК" бүлэглэлийн хооронд дэгдсэн зэвсэгт мөргөлдөөнд 220 мянган хүн амь үрэгдэж, зурган сая хүн эх орноосоо дайжихад хүрчээ. Тэгвэл дэлхий дахинаа энх тайван тогтоох үйлсэд хучин чармайлт гаргасныг нь Нобелийн хороо өндрөөр үнэлж, Колумбийн Ерөнхийлөгч Хуан Мануэль Сантосыг энэ оны Нобелийн Энх тайвны шагналтнаар тодруулсан юм. Тэрбээр уг шагналыг дагалддаг найман сая крон буюу 925 мянган ам.долларыг иргэний дайнд хохирсон хүмүүст хандивлахаа мэдэгдсэн удаатай. Нобелийн шагналын бас нэгэн өвөрмөц тэрх нь АНУ-ын алдарт дуу зохиогч, дуучин Боб Дилан байлаа. Түүнийг Нобелын утга зохиолын шагналд тодорхойлсон ч, шагналаа авах авахгүй нь удтал тодорхой бус байсны эцэст өөрийн биеэр гардаж аваагүй ч, төлөөлөгчөө илгээсэн байсан юм. Түүнчлэн, шинжлэх ухааны сонин содон нээлт хийсэн эрдэмтэд ч шагналаа гардсан бөгөөд Нобелийн эдийн засгийн шагналыг Их Британийн эрдэмтэн, АНУ-ын Харвардын их сургуулийн багш Оливер Харт, Финляндын эрдэмтэн, АНУ-ын Массачусетсийн Технологийн институтын багш Бэнгт Холстём нар хүртэв.



## 9. Домогт удирдагчид таалал төгслөө





Хэдий бараан мэдээлэл ч гэлээ, энэ онд олны танил маш олон алдартан тэнгэрт хальсан байдаг. Гэхдээ энэ удаа домогт удирдагчдыг нэрлэе. ЗХУ нуран унаснаас хойш Узбекистан улсыг тасралтгүй хатуу гарын дор удирдаж байсан Ислам Каримов өвчний улмаас таалал төгссөн юм. Түүний үхлийн талаархи мэдээлэл цацагдаж эхэлмэгц олон улсын ажиглагчид тус улсыг "даритай торх мэт болсон" хэмээн зүйрлүүлж байлаа. Ийнхүү 25 жилийн турш И.Каримов гэх ганц л удирдагчтай байж ирсэн Узбекистан улсын төрийн тэргүүн солигдож, Ерөнхий сайд Шавкат Мирзияев түүнийг халаар авсан нь мөн л энэ жилийн онцлох агшин байв. Афганистантай хиллэдэг, лалын гол улсын нэг Узбекистаныг лалын ариун дайчдын тэмцлээс хатуу гарын дор хамгаалж ирсэн И.Каримов таалал төгссөний дараа хаан сэнтийд хамгийн удаан хугацаанд заларсан Тайландын ээзн хаан Пумипон Адульядет 88 насандаа өвчний улмаас тэнгэрт хальсан юм. Улс орны ээ нэгдлийн бэлгэдэл болсон эрхмийг нас барсны дараа тус улсад хар хувцасны хомсдол үүсч эхэлсэн гэдэг. Улмаар энэхүү эмгэнэлт явдлаас хойш сар гаруй хугацааны дараа түүний хүү Маха Вачиралонгкорн хаан сэнтийд заларсан юм. Ийнхүү тайландчууд 70 жилийн дараа шинэ ээзн хаантай болов. Тэгвэл энэ явдлаас төд удалгүй 20 дугаар зууны сүүлчийн хагаст дэлхийн хүчирхэг, нөлөө бүхий удирдагчдын нэг гэгддэж явсан Кубын удирдагч Фидель Кастро 90 насандаа таалал төгссөн юм. Улстөрийн ертөнцийг хэзээ ч орхихгүй хэмээж явсан тэрээр 2006 оны долдугаар сард эрх мэдлээ өөрийн дүү Рауль Кастрод шилжүүлсэн. Харин Рауль төрсөн ахыгаа залгамжлан Куба улсыг толгойлохдоо эдүгээг хүртэл баримталж ирсэн улс төрийн бодлогод эргэлт хийж, АНУ-ын Засгийн газартай харилцаагаа зөөлрүүлэх алхмыг хийсэн юм.



## 10. Алеппо чөлөөлөгдөв

Сири Улсад гал зогсоох талаар АН, ОХУ тохиролцоонд хүрсэний хоёрдугаар сарын 27-нд зарлав. Сирийн Ерөнхийлөгч Башар Асад ч тохиролцоог албан ёсоор хүлээн зөвшөөрчээ. Үүнээс яг нэг сарын дараа Сирийн арми Оросын дэмжлэгтэйгээр эртний түүхт Пальмир хотыг Лалын хэт даврагчдын гараас чөлөөллөө. Пальмирт байлдаж байсан Лалын улс бүлэглэлийн дайчид хөрш зэргэлдээ Иракийн нутаг болон Дэйр аз Зур хот руу зугтаасан байна. Оны эцсээр Сирийн арми ОХУ-ын тусламжтайгаар Алеппо хотыг бүрэн чөлөөлөв. Алеппо хотыг эзлэн авахын тулд Сирийн армийнхан болон тэдэнд тусалсан Оросын цэргийнхэн тус хотын зүүн хэсэгт бүгсэн террористуудыг хүчтэй бөмбөгдсөнийг Барууны зарим хөгжилтэй улс орон, тэр ч байтугай НҮБ-ын Хүний эрхийн асуудал эрхэлсэн комиссар Зэйд Раад Аль Хусейн хүртэл дайныг хэтэрхий харгис аргаар явуулж жирийн иргэдийн амь насанд хор хохирол учруулж байна хэмээн буруушаан зэмлэв. Сирийн арми хамаг анхаарлаа Алеппо хотыг эзлэн авах ажиллагаанд хандуулсан байх хойгуур Лалын улс бүлэглэлийнхэн эртний түүхт Пальмир хотыг дахин эзлэв. Ингэсэн нь лалын шашны нэрийг барьсан террористуудтай тэмцэж байгаа улс орнууд, ялангуяа АНУ, ОХУ зэрэг томоохон улс орнууд террористуудын эсрэг явуулж буй байлдааны үйл ажиллагаагаа хооронд нь уялдуулахгүй байгаатай шууд холбоотой гэж ажиглагчид үзжээ. Гэхдээ АНУ-ын шинэ Ерөнхийлөгч Доналд Трамп террористуудын эсрэг тэмцэлд ОХУ-тай хамтран бодолтой байгаагаа илэрхийлсэн. Ингэснээр ирэх жилүүдэд АНУ, ОХУ алан хядагчдын эсрэг нэг бодлого баримталснаар цуст дайнд цэг тавигдаж магадгүй гэх хүлээлт ч үүсээд байна.

NO STRESS

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# “Оны онцлох” хүүхдүүд ШАЛГАРЛАА

Н.БАТЗАЯА


Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран 2016 онд сурлага, урлаг, спорт, хүмүүнлэгийн сайн үйлсээрээ бусдыгаа манлайлсан “Оны онцлох” 20 сурагчийг өчигдөр тодруулллаа. Энэ оны шилдэгхүүхэдбагачуудыгХүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газрын дарга О.Алтансүх хүлээн авч уулзан “Онцлох хүүхэд” өргөмжлөл, “Шилдэг хүүхэд” медалийг гардуулахын хамт “Олон хүмүүст туслаж, ээрэг сайхан өөрчлөлтийг авчирсан Монгол Улсын сайн иргэн болоорой” хэмээн сурагчдад захисан юм.

Энэ удаагийн шалгаруулалтад нийт 20 аймаг, есөн дүүргийн 115 хүүхэдесөнноминацидөрсөлдсөн бөгөөд үе тэнгийнхнийгээ манлайлсан шилдэг 20 сурагчийг шалгаруулжээ. Тодруулбал, энэ жилийн “Оны онцлох хүүхэд” шагналын эздээр таван настайгаасаа дуулж, долоон настайгаасаа ая зохиож, найман настайгаасаа нотолж сурсан Хөгжим бүжгийн коллежийн сурагч Б.Өнөржаргал, Ази тивийн даамын гурван удаагийн аварга Э.Хүслэн, Ой тогтоолтын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс гурван төрлөөр алтан медаль хүртэн нэг төрлөөр рекордын эзэн болсон Э.Пүрэвжав, “Баярлалаа” сайн үйлсийн аяныг зохион байгуулж 1,280,000 төгрөгийн хандив цуглуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тусалсан Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 1 дүгээр сургуулийн 12 дугаар ангийн сурагч Э.Бүрэнчөдөр нар шалгарчээ. Мөн ардын уламжлалт тоглоом наадгайг үе тэнгийнхэндээ заан сургаж, ардын уламжлалт өв соёлоо түгээн дэлгэрүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулж яваа сурагч Х.Мөнхшагай, галын аюулаас иргэний амь нас, эд хөрөнгийг авран хамгаалсан Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 12а ангийн сурагч С.Амарзаяа, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын “Гурван-Эрдэнэ” ерөнхийболовсролынсургуулийн 7в ангийн сурагч Д.Бямбадорж нарын сурагчид шалгарч, үе тэнгийнхнээ манлайллаа. Энэ үеэр “Байгаль хамгаалал, эрүүл аюулгүй орчин” номинацид шалгарсан Б.Батлхагва “Намайг Бат-Өлзийгийн Батлхагва гэдэг. Би 16 настай. Ховд аймгийн Манхан сумын ахлах сургуулийн 11б ангид сурдаг. Би 2016 онд “Хавх булаагүй ууланд амьтан жаргалтай” аяныг зохион байгуулсан.



Энэхүү аяныг орон даяар өрнүүлэх санаалчилгыг Байгаль орчны сайдад хүргүүлсний дагуу хавхны хор хөнөөлийн талаар хэвлэл мэдээллээр сурталчилсан. Мөн баруун бүсийн чуулганы үеэр энэ талаар сургалт хийсэн. Түүнчлэн өнгөрсөн арваннэгдүгээр сард Дэлхийн байгаль хамгаалах сан, гадны донор байгууллагуудын зохион байгуулсан Ирвэс хүзүүвчлэх аянд амжилттай оролцсон. Энэ аяныхаа дагуу ОХУ-д очиж туршлага солилцох урилга авсан. Маш их баяртай байна” гэв. Үүний дараа оны онцлох хүүхдүүдийг Монгол Улсын Ерөнхий сайд, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн тэргүүн Ж.Эрдэнэбат хүлээн авч уулзлаа.

Тэрбээр, сурлага, урлаг, спортоороо тэргүүлсэн шилдэг сурагчдад хандан “Улс эх орныхоо ирээдүй хойч болсон дүү нартаа шинэ жилийн баярын мэнд дэвшүүлье. Мэдлэгтэй, боловсролтой, чадвартай иргэн болж өсөж байгаад талархаж байна. Та бүхнийг харахад Монгол Улсын хөгжил, ирээдүй гэрэл гэгээтэй харагдаж байна. Боловсролтой, мэдлэгтэй байх нь ирээдүйн амьдралын баталгаа гэж ухамсарлаж, эцэг эхдээ энэрэлтэй, эх орондоо хэрэгтэй сайн хүн болоорой гэж хүсэн ерөөе” гэсэн юм.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр -13
Шөнө -25

Нөгөөдөр
Өдөр -11
Шөнө -22

Өдрийн зурхай

**ӨВЛИЙН ДУНД ЦАГААН ХУЛГАНА САР ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ХӨХ БИЧ ӨДӨР**

**Аргын тооллын:** 2016.12.28, Лхагва гараг
**Наран ургах шингэх:** 08.42-17.07
**Үс засуулбал:** Сүлд тэнэж одно
**Барилдлага:** Рашаан
**Шүтэн барилдлага:** Сэрэхүй



*Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд ээрэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр насны хүч дэлгэрнэ. Эм найруулах, угаал үйлдэх, бэр авах, насны авшиг, насны бүтээл хийх зан үйл хийгээд төрөл садан бололцох, худалдаа наймааны үйл, атрaг лугаа золгох, авшиг авах, ус гатлах, угаах зэрэгт сайн. Баруун нүд татвал садан ирэх, зүүн нүд татвал баярлах, баруун чих хангинавал гутамшиг болох, зүүн хангинавал завхарсныг сонсож цочих, бие татвал өмнө зүгээс зочин ирэх, хөл татвал хэрүүл гомдол болох болой. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой.*


